



Европын Холбоо
санхүүжүүлэв



Food and Agriculture
Organization of the
United Nations



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага



ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ “МОНГОЛ УЛСАД ТОГТВОРТОЙ
ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОЙ УЯЛДСАН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР
ЭРХЛЭЛТИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ НЬ” ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ХӨТӨЛБӨР АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛСАН ТӨСӨВ, ХҮРСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Улаанбаатар хот

2024 он

ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ “МОНГОЛ УЛСАД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТой УЯЛДСАН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ НЬ” ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ХӨТӨЛБӨР АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛСАН ТӨСӨВ, ХҮРСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайланг боловсруулсан:

А.Мөнх-Оргил, НҮБХХ-ийн зөвлөх

Г.Түвшинтуяа, НҮБХХ-ийн зөвлөх

Хянан тохиолдуулсан:

Н.Мөнхсүх, Сангийн яамны Төрийн сангийн газрын, Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга

Энэхүү “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны хагас жилийн хөтөлбөр арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнгийн тайлан”-г Европын Холбооны санхүүжилттэй “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд боловсруулав. Төслийг Европын Холбооны санхүүжилтээр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллагатай хамтран хэрэгжүүлдэг.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр нь ядуурал, тэгш бус байдал болон уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй шударга бус байдлыг эцэслэх зорилго бүхий НҮБ-ын тэргүүлэх байгууллага юм. Дэлхийн 170 орны түншлэгчид болон мэргэжилтнүүдийн өргөн цар хүрээт хамтын ажиллагааны дүнд эх дэлхий, хүн бүрийн сайн сайхны төлөө хөгжлийн урт хугацааны, цогц шийдлийг бий болгоход улс үндэстнүүдийг дэмжин ажилладаг.

Европын Холбоо бол Европ тивийн 27 тусгаар улсын эдийн засаг, улс төрийн нэгдэл юм. Тус Холбоо нь хүний эрхэм чанар, эрх чөлөө, ардчилал, эрх тэгш байдал, хууль дээдлэх ёс, хүний эрхийг түүний дотор цөөнхийн эрхийг дээдлэх үндсэн үнэт зүйлс дээр тулгуурлан байгуулагджээ. Өнөө цагт Европын Холбоо нь даян дэлхийн хүн бүрд хүртээмжтэй, нийгэм, эдийн засаг, байгаль орчны тогтвортой хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаа явуулж байна.

Ерөнхий мэдэгдэл

Тайлангийн агуулга зөвхөн зохиогчдын үзэл бодлыг илэрхийлж байгаа бөгөөд Европын Холбоо болон НҮБХХ-ийн албан ёсны бодлого, байр суурийг илэрхийлээгүй. Энэхүү тайланд ашигласан мэдээллийн үнэн зөв эсэх, тухайн материалыг ашигласны улмаас гарах үр дагаварт Европын Холбоо, НҮБХХ хариуцлага хүлээхгүй болно. НҮБХХ-ийн зөвшөөрөлгүйгээр энэхүү хэвлэлийг худалдах, эсвэл ямар нэгэн ашиг олох хэрэгсэл болгохыг хориглоно.

ISBN: 978-9919-9195-2-8

АГГУУЛГА

01.

УЛСЫН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧДЫН
ХӨТӨЛБӨР АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛСАН ТӨСӨВ,
ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

02.

ОРОН НУТГИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧДЫН
ХӨТӨЛБӨР АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛСАН ТӨСӨВ,
ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

03.

МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ХӨТӨЛБӨРИЙН
ШИНЖИЛГЭЭ

04.

“ОРОН НУТАГТ ҮР ДҮНД СУУРИЛСАН НЭГДСЭН
УДИРДЛАГЫГ ХЭВШҮҮЛЭХ НЬ” СЭДЭВТ ДЭМЖИХ
ХӨТӨЛБӨРИЙН 3 ҮЕ ШАТНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

САНГИЙН ЯАМ, НҮБ-ЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР ТӨСЛИЙН ХҮРЭЭНД УЛСЫН ХЭМЖЭЭНД 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ХАГАС ЖИЛД ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛСАН ТӨСӨВ, ХҮРСЭН ҮР ДҮНГИЙН ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАНГ АНХ УДАА НЭГТГЭН БОЛОВСРУУЛАВ.

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ) нь “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” техникийн туслалцааны төслийг Европын Холбооны санхүүгийн дэмжлэгээр хэрэгжүүлж байна. Сангийн яам нь энэхүү төслийг НҮБХХ-тэй хамтран хэрэгжүүлж байна.

Төслийн дэмжлэгийн хүрээнд Монгол Улсад бодлого ба төсвийн уялдааг хангах, үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийг ТХЗ-ийн тэргүүлэх салбар, хөтөлбөрүүдэд нэвтрүүлэх, дунд хугацааны зарлагын хүрээнд шилжих бодлогын хувилбарыг тодорхойлох болон түүний тайлагнал, хяналт шинжилгээ хийх арга зүйг бий болгох, хувилбарыг турших зэрэг үйл ажиллагаа явуулж байна.

Төслийн “Тайлагнал” хариуцсан бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааг зохицуулах заавар, аргачлалыг Сангийн сайдын 2023 оны 225 дугаар тушаалаар батлуулсан. Тус аргачлалын хүрээнд тус тайланг хоёр дох жилдээ улсын хэмжээнд нэгтгэж байгаа бөгөөд 2024 оны эхний хагас жилийн энэхүү тайлан нь хагас жилийн тайлан улсын хэмжээнд нэгтгэсэн анхны туршлага болж байна.

Тус тайланд хөтөлбөр, арга хэмжээний 2024 оны хагас жилд тайланд тайлагнагдсан болон төсөв хуваарилагдсан хөтөлбөрийн шинжилгээг тусад нь бүлэг болгон оруулсан бөгөөд тус шинжилгээнд хөтөлбөр бүрт санал болгосон хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлтийн дагуу Сангийн яамны Төрийн сангийн газраас шинэчилж буй Засгийн газрын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн цахим системд нэвтрүүлсэн.

Тайлант хугацаанд орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчидын 2023 оны эхний хагас жилийн тайлан нь 20 орон нутгийн ТЕЗ хувьд аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын дунд зохион байгуулсан “ОРОН НУТАГТ ҮР ДҮНД СУУРИЛСАН НЭГДСЭН УДИРДЛАГЫГ ХЭВШҮҮЛЭХ НЬ” сэдэвт дэмжих хөтөлбөрийн 3 дахь үе шатын үнэлгээний суурь мэдээлэл болсноороо онцлогтой.

Иймд тус тайлангийн хүрээнд зөвхөн дэмжих хөтөлбөрт хамрагдсан орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын үнэлгээ нь тайлангийн нэг бүрэлдэхүүн болсон.

Сангийн яамны Төрийн сангийн газар

ХУРААНГУЙЛСАН ҮГС

ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЕТГ	Ерөнхийлөгчийн Тамгын Газар
ЗГХЭГ	Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар
ТЕЗ	Төсвийн Ерөнхийлөн Захирагч
УИХ	Улсын Их Хурал

АГУУЛГА

МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХӨТӨЛБӨР АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛСАН ТӨСӨВ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ.....	7
УЛСЫН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧДЫН ХӨТӨЛБӨР АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛСАН ТӨСӨВ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ.....	9
ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧДЫН ХӨТӨЛБӨР АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛСАН ТӨСӨВ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ.....	14
ТӨСВИЙН ХӨТӨЛБӨРИЙН ШИНЖИЛГЭЭ	22
ДҮГНЭЛТ, САНАЛ	135
ОРОН НУТАГТ ҮР ДҮНД СУУРИЛСАН НЭГДСЭН УДИРДЛАГЫГ ХЭВШҮҮЛЭХ НЬ” СЭДЭВТ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРИЙН 3 ДУГААР ҮЕ ШАТНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН.....	140
ХАВСРАЛТ.....	155

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1 Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын 2024 оны хөтөлбөр, арга хэмжээний тайлангийн үзүүлэлт.....	9
Зураг 2 Улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрийн тоо	10
Зураг 3 Улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн тоо	10
Зураг 4 Улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны хагас жилийн төсөв, гүйцэтгэл, гүйцэтгэлийн хувь /тэрбум төгрөгөөр/	11
Зураг 5 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын 2023 оны хөтөлбөр, арга хэмжээний тайлангийн үзүүлэлт.....	14
Зураг 6 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрийн тоо	15
Зураг 7 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн тоо	17
Зураг 8 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсөв, гүйцэтгэл, гүйцэтгэлийн хувь /аймгаар, тэрбум төгрөгөөр/	19
Зураг 9 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсөв, гүйцэтгэл, гүйцэтгэлийн хувь /хөтөлбөрөөр, сая төгрөгөөр/	20

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Монгол Улсын 2024 оны хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрэх үр дүнгийн тайлангийн тоон үзүүлэлт (улсын болон орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч багтсан байдлаар).....	8
Хүснэгт 2 Улсын төсвийн шалгуур үзүүлэлтийн шинжилгээ	11

МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХӨТӨЛБӨР АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛСАН ТӨСӨВ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасан Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг болох Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв хүрсэн үр дүнгийн тайланг тайлагнах эрх зүйн актыг 2023 оны 12 дугаар сард Сангийн сайдын 225 тоот тушаалаар батлуулсан билээ. Уг тушаалын хэрэгжилтийг хангаж улсын хэмжээнд анх удаа батлагдсан төсвөө үр дүнтэйгээ уялдуулан үр ашгаа тайлагнаж байгаа энэ удаагийн тайлангийн онцлог болж байна. Монгол Улсын 2024 оны хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүрэлдэхүүн болох “Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн”-ийн тайланд улсын төсвийн 38, орон нутгийн төсвийн 22 ерөнхийлөн захирагчдын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, хүрэх үр дүнгийн тайланг холбогдох журмын дагуу нэгтгэсэн¹. Үүнд нийт 591² хөтөлбөрийн үр дүнг нэгтгэсэн бөгөөд үүнээс 540 хөтөлбөрийн 712 үр дүн нь 85% хүртэл гүйцэтгэлтэй, 24 хөтөлбөрийн 40 үр дүн нь 85%-100%-ийн гүйцэтгэлтэй, 27 хөтөлбөрийн 56 үр дүн нь 100%-с дээш гүйцэтгэлтэй буюу нийт батлагдсан хөтөлбөрийн 85 хувь нь буюу 456 хөтөлбөр төлөвлөсөн үр дүндээ хүрсэн байна.

Зарцуулсан төсөв болон хөтөлбөрийн гүйцэтгэлээр 85%-аас бага үр дүнтэй хөтөлбөрийн дундаж үр ашиг нь -14% буюу үр ашиггүй, 85%-100%-ийн гүйцэтгэлтэй хөтөлбөрийн дундаж үр ашиг 64% бол 100%-ээс дээш үр дүнтэй хөтөлбөрүүд 232%-ийн үр ашигтай байна. Тус тайлангийн үр дүн 2023 оны жилийн эцсийн шинжилгээтэй харьцуулахад доогуур байгаа нь (1) хөтөлбөр, арга хэмжээний хагас жилийн тайлангийн зорилтот түвшин төсвийн хавсралтын батлагдсанаар буюу жилийн дүнгээр, хүрсэн түвшин хагас жилээр тайлагнагдаж байгаа болон (2) төсвийн гүйцэтгэл эхний хагас жилд хэрэгжүүлэх арга хэмжээ, худалдан авах ажиллагааны зохион байгуулалт, бодлогын баримт бичгийн баталгаажуулалт удаашралтай зэргээс шалтгаалан бага буюу нэгдсэн дунджаар 70 байгаагаас шалтгаалж байна. Хөтөлбөрийн төсвийн гүйцэтгэлийн хэмжээ төсвийн үр ашигт уялдахдаа гүйцэтгэлтэй 85 болон түүнээс дээш хувьтай хэрэгжсэн тохиолдолд хөтөлбөрийн төлөвлөсөн арга хэмжээ үр дүнтэй хэрэгжиж, үр ашгийг бүрдүүлж байна.

¹ Сангийн сайдын 2023 оны 225 дугаар тушаал. “Маягт аргачлал батлах тухай”

² Давхардсан тоогоор

Хүснэгт 1. Монгол Улсын 2024 оны хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрэх үр дүнгийн тайлангийн тоон үзүүлэлт (улсын болон орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч багтсан байдлаар)

Хөтөлбөрийн гүйцэтгэлийн ангилал	Хөтөлбөрийн тоо	Хүрэх үр дүнгийн тоо	Шалгуур үзүүлэлтийн тоо	Төсвийн гүйцэтгэлийн хувь	Хүрсэн түвшний гүйцэтгэлийн хувь	Хөтөлбөрийн гүйцэтгэл	Үр ашиг
100%-ээс дээш	27	56	104	63%	245%	278%	232%
85%-100%	24	40	70	42%	99%	100%	64%
85%-аас бага	540	712	952	69%	62%	53%	-14%
НИЙТ	591	808	1,126	70%	84%	84%	16%
Улсын төсөв							
Хөтөлбөрийн гүйцэтгэлийн ангилал	Хөтөлбөрийн тоо	Хүрэх үр дүнгийн тоо	Шалгуур үзүүлэлтийн тоо	Төсвийн гүйцэтгэлийн хувь	Хүрсэн түвшний гүйцэтгэлийн хувь	Хөтөлбөрийн гүйцэтгэл	Үр ашиг
100%-ээс дээш	19	49	95	82%	298%	363%	282%
85%-100%	20	36	66	75%	93%	94%	32%
85%-аас бага	57	134	248	66%	41%	23%	-40%
НИЙТ	96*	219	409	70%	84%	84%	16%
Орон нутгийн төсөв							
Хөтөлбөрийн гүйцэтгэлийн ангилал	Хөтөлбөрийн тоо	Хүрэх үр дүнгийн тоо	Шалгуур үзүүлэлтийн тоо	Төсвийн гүйцэтгэлийн хувь	Хүрсэн түвшний гүйцэтгэлийн хувь	Хөтөлбөрийн гүйцэтгэл	Үр ашиг
100%-ээс дээш	8	7	9	45%	193%	194%	182%
85%-100%	4	4	4	8%	105%	105%	97%
85%-аас бага	483	578	704	71%	83%	82%	13%
НИЙТ	495**	589	717	70%	84%	84%	16%


*Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлтгүй боловч төсөв батлагдаагүй 4 хөтөлбөрийг хассан

** Төв аймаг нэгтгэлд оруугүй тул орон нутгийн 21 аймгийн мэдээлэл багтсан.

УЛСЫН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧДЫН ХӨТӨЛБӨР АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛСАН ТӨСӨВ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Монгол улсын 2024 оны төсвийн тухай хуулийн “Төсвийн ерөнхийлөн захирагчдын 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт”³ дагуу 38 төсвийн ерөнхийлөн захирагчийн⁴ хэрэгжүүлэх 100 хөтөлбөр, 219 хөтөлбөрийн үр дүнд нийт 409 хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг баталсан.

Тайлант хугацаанд 57 хөтөлбөрийн 134 үр дүн нь 85% хүртэл гүйцэтгэлтэй, 20 хөтөлбөрийн 36 үр дүн нь 85%-100%-ийн гүйцэтгэлтэй, 19 хөтөлбөрийн 49 үр дүн нь 100%-с дээш гүйцэтгэлтэй байна. Үүнд хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт батлагдаагүй төсөвтэй 4 хөтөлбөр ороогүй.




Зураг 1 Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын 2024 оны хөтөлбөр, арга хэмжээний тайлангийн үзүүлэлт

³ Монгол улсын төсвийн 2024 оны төсвийн тухай хууль. Нэгдүгээр хавсралт. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт

⁴ 2024 оны хагас жилийн тайлан учир 2024 оны батлагдсан төсвийн дагуу тайлагнагдсан тул ТЕЗ-ийн тоо хуучин тоогоор хянагдсан.

ХӨТӨЛБӨР




Зураг 2 Улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрийн тоо

Улсын төсвийн 38 ерөнхийлөн захирагчийн хагас жилийн санхүүгийн тайлангаа нийт 100 хөтөлбөр батлагдсанаас давхардаагүй тоогоор 98 хөтөлбөрт хуваарилагдсан байна. Үүнээс нийт 23 төсвийн ерөнхийлөн захирагч буюу 60 хувь нь нэг хөтөлбөртэй бол хамгийн олон хөтөлбөртэй төсвийн ерөнхийлөн захирагч нь Хууль зүй, дотоод хэргийн сайд 13 хөтөлбөртэй байна.

Тус хөтөлбөр нь төрийн сангийн бүртгэлийн хөтөлбөртэй

ижил бөгөөд төсвийн жилийн дундуур төсөвт нэмэлт өөрчлөлт оруулснаар 4 төсвийн ерөнхийлөн захирагч дээр 4 хөтөлбөр нь төсвийн хавсралтад батлагдаагүй бөгөөд үр дүнгүй, гүйцэтгэл гарсан байна. Иймд цаашид төсөв хуваарилагдсан хөтөлбөр бүрийг үр дүнтэй уялдуулах шаардлагатай.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН



Зураг 3 Улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн тоо

Улсын төсвийн 38 ерөнхийлөн захирагчийн жилийн эцсийн санхүүгийн тайлангаар нийт нийт 219 хөтөлбөрийн хүрэх үр дүн батлагдсан. Нийт төсвийн ерөнхийлөн захирагчийн 19 нь буюу 50 хувь нь 1-3 хөтөлбөрийн үр дүнтэй байна. Хамгийн олон хөтөлбөрийн үр дүнтэй төсвийн ерөнхийлөн захирагч нь Хууль зүй, дотоод хэргийн сайд байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрөөс 51 хөтөлбөр тус бүр хоёроос дээш хүрэх үр дүнтэй бөгөөд бусад хөтөлбөр нь тус бүр нэг хөтөлбөрийн хүрэх үр

дүнтэй байна. Монгол Улсын 2024 оны төсвийн төслийг боловсруулах удирдамжийн⁵ дагуу хөтөлбөрийн хүрэх үр дүнд тавьсан шаардлагын хүрээнд нийт жилийн эцсийн тайлангийн хүрээнд судалж үзлээ. Удирдамжид нэг хөтөлбөрт 3-с дээшгүй үр дүнг тодорхойлох чиглэлтэй боловч 15 хөтөлбөр 3-аас дээш хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй батлагдсан байна.

Хүрэх үр дүнг тодорхойлох талаар дараах 4 үндсэн зарчим баримтлахыг зөвлөдөг бөгөөд нийт 219 хөтөлбөрийг дараах байдлаар үнэллээ.

⁵ Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамж. ТМ-01а маягт бөглөх заавар. Эх сурвалж: Сангийн яам www.mof.gov.mn


Хүснэгт 2 Улсын төсвийн шалгуур үзүүлэлтийн шинжилгээ

Зарчим	Хангасан	Эзлэх хувь
Хаана хэрэгжих (байршил)	52	19%
өөрчлөлтийг хэн хүртэх (үр шим хүртэгч, оролцогч тал)	63	29%
Юуг өөрчлөхөөр зорьж байгааг	184	84%
Хүлээгдэж буй өөрчлөлтийн чиглэл (нэмэгдүүлэх/бууруулах)	120	55%

Нийт 219 үзүүлэлтийн шаардлагыг хангасан эсэхийг тооцоход “юуг өөрчлөхөөр зорьсон” үзүүлэлт хангалттай хангагдсан буюу 84 хувь байна. Энэ нь хөтөлбөрийн үр дүнд тухайн хөтөлбөрийг гол хэмжих зүйл болон хүчин зүйлийг дурдсан тул шаардлага хангаж байна. Харин бусад үзүүлэлтүүд хангалтгүй байгаа бөгөөд “товч тодорхой” байх зарчим ч мөн хангагдахгүй байна. Иймд цаашид хөтөлбөрийн үр дүнг төлөвлөхдөө удирдамжийн зарчим, шаардлагыг анхаарч боловсруулах шаардлагатай байна.

ХӨТӨЛБӨРИЙН ТӨСӨВ, ГҮЙЦЭТГЭЛ

Монгол Улсын 2024 оны батлагдсан төсвийн дагуу улсын төсвийн нийт 38 төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад нийт 20.8 их наяд төгрөг батлагдсан бөгөөд эхний хагас жилд 10.8 их наяд төгрөг буюу 52 хувь нь батлагдсан. Оны эхний хагас жилийн байдлаар 9.4 их наяд төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 87 хувийн гүйцэтгэлтэй санхүүжсэн байна.



Зураг 4 Улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны хагас жилийн төсөв, гүйцэтгэл, гүйцэтгэлийн хувь /тэрбум төгрөгөөр/


Төсвийн гүйцэтгэлийг төсвийн ерөнхийлөн захирагч тус бүрээр судалж үзэхэд 100 хувийн санхүүжилттэй буюу зарцуулсан хөрөнгийг бүрэн зарцуулсан 1 төсвийн ерөнхийлөн захирагч байна. Нийт 38 төсвийн ерөнхийлөн захирагчаас 11 ТЕЗ-ын багц улсын дундаж 87 хувьтай тэнцүү

буюу илүү гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна. Энэ нь цаашид эдгээр төсвийн хөтөлбөрүүдийн үр дүнтэй болон үр ашигтай хэрэгжсэн байх нөхцлийг бүрдүүлэх юм.

Нийт 100 хөтөлбөрийг төсвийн гүйцэтгэлээр ангилж үзэхэд 32 хөтөлбөр нь 87 хувь болон түүнээс дээш хувийн гүйцэтгэлтэй байна. Эдгээр бүрэн санхүүжиж хэрэгжсэн хөтөлбөрт оногдох нийт төсвийн гүйцэтгэл нь 6.7 их наяд буюу нийт төсвийн 62 хувь оногдож байна.


ХӨТӨЛБӨРИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Улсын төсвийн нийт 38 төсвийн ерөнхийлөн захирагчдын хөтөлбөрт нийт 409 шалгуур үзүүлэлт батлагдсан.




Төсвийн ерөнхийлөн захирагч дунджаар 3 шалгуур үзүүлэлттэй ба 10 болон түүнээс дээш шалгуур үзүүлэлттэй 11 төсвийн ерөнхийлөн захирагч байна. Шалгуур үзүүлэлтийн тоо хөтөлбөр болон хүрэх үр дүнгийн тоо болон төсвийн хэмжээтэй хамааралтай. Хамгийн олон үр дүнгийн шалгуур үзүүлэлттэй төсвийн ерөнхийлөн захирагч нь:

1. Байгаль орчин, аялал жуулчлал
2. Хууль зүйн сайд
3. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
4. Боловсрол, шинжлэх ухааны сайд байна.



Нийт 409 шалгуур үзүүлэлтийн 133 нь буюу 67 хувь нь чанарын, 276 нь тоон шалгуур үзүүлэлт батлагдсан байна. Харин



нийт шалгуур үзүүлэлтийн 98 хувь буюу 402 нь өсөх хандлагатай төлөвлөгдсөн.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг SMART шинж чанараар үнэлгээ өгөх нь хүндрэлтэй бөгөөд судлаачийн үзэл бодол хэт нөлөөлөх юм. Бүх үзүүлэлт юуг, хэрхэн хэмжих нь тодорхой мөн тухайн хөтөлбөрт улсын төсвийн эх үүсвэрээс санхүүжилт батлагдсан нь шалгуур үзүүлэлтийг биелэгдэхүйц болгож байна. Ач холбогдлын хувьд улсын төсөвт баталж байгаа нь тухайн хөтөлбөр болон шалгуур үзүүлэлтийг ач холбогдолтой болгож байна. Иймд цаашид анхаарах шаардлагатай байдлаар төсвийн ерөнхийлөн захирагч нарт түгээмэл гарч байгаа зарим асуудлыг доор дурдав.

Улсын төсвийн хөтөлбөр, арга хэмжээний тайлан нэгтгэхэд гарсан зарим хүндрэлийн жишээнээс:

1. Төсвийн ерөнхийлөн захирагчидын 2024 онд хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг тайлагнахад хүндрэлтэй байсан болон төсөв зарцуулж хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гарах үр дүн, үр нөлөөтэй уялдаагүй байсан зэрэг асуудлыг шийдвэрлээгүй, 2023 онтой ижил байдлаар төлөвлөсөн. Түүнчлэн дараах асуудлууд нийтлэг байна:

- Төсвийн тайлагналын бүх үе шатанд хөтөлбөр, үр дүнгийн тайланг хагас жилээр тайлагнах, нэгтгэх, хянах үйл ажиллагаа төлөвшөөгүйгээс шалтгаалан техник алдаа, зөрүү ихтэй байна.

- Хөтөлбөр, үр дүнгийн тайлангийн суурь болон зорилтот түвшний мэдээлэл, үндэслэх эх сурвалж, аргачлал тодорхойгүй байгаас үр дүн зөрүүтэй гарах магадлалтай.

- Хөтөлбөр, үр дүнгийн тайлангийн төлөвлөх, төсөвлөх, тайлагнах, хяналт шинжилгээ хийх үе шатанд боловсруулсан арга зүй, зөвлөх үйлчилгээ, журмын танилцуулга, зөвлөх үйлчилгээний үр дүнг төсвийн ерөнхийлөн захирагчидын ашиглалт хангалтгүй байна.

- Тайланг хариуцаж нэгж, албан хаагч тодорхойгүй байгаагаас шалтгаалан тайлан удаашралтай, эх сурвалж тодорхойгүй, хариуцлагагүй байдал үүсэж байна.

- Монгол Улсын 2024 оны төсвийн төслийн удирдамжид Ангилагдаагүй бусад хөтөлбөрт төсөв төлөвлөхгүй чиглэл гаргасан боловч тус хөтөлбөр нь ашиглагдсан. Цаашид төсөв хуваарилагдсан бүх хөтөлбөрийг үр дүн, үр ашигтай уялдуулах шаардлагатай.

2. Улсын хэмжээнд нэгтгэгдсэн тайлангаас цаашид төлөвлөлтөд анхаарах шаардлагатай зарим жишээг доор дурдав /ТЕЗ жишээ байдлаар авсан/:

- Ерөнхий сайд: Тагнуул, нууцын байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл Төсвийн хуулийн хавсралтаар батлагддаггүй ч тухайн ТЕЗ-ын төсөв, гүйцэтгэл дээр нэмж гардаг. Мөн зорилтот түвшний шалгуур үзүүлэлтийг 3 үзүүлэлтийг өгүүлбэрээр хамтад нь баталсан. Жнь: Яам-16, аймаг-21, нийслэл, дүүрэг-10

- Шадар сайд: Төрийн худалдан авах ажиллагааны газрын төсөв Төсвийн тухай хуулийн хавсралтаар батлагддаггүй боловч төсөв, гүйцэтгэл нь сайдын багцад тайлагнадаг.


- Үндсэн хуулийн цэцийн дарга: Шалгуур үзүүлэлтийн суурь түвшин болон зорилтот түвшин дээр өгүүлбэрээр буюу Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байх гэж баталсан нь хүрсэн түвшний гүйцэтгэлийн хувийг тайлагнах боломжгүй.

- Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхий сайд: Нэг шалгуур үзүүлэлтийг “Хуулийн төсөл-557, тогтоолын төсөл-84” гэх мэт хоёр үзүүлэлтээр хэмжихээр баталсан нь тайлагнахад хүндрэлтэй.

- ЗГХЭГ: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар Төсвийн хуулиар батлагдаагүй ч сайдын багцад тайлагнадаг. Мөн Хөтөлбөртэй байх шаардлагагүй. Зөвхөн ажлын албадын урсгал зардлууд тусч батлагдсан. ТЕЗ-ийн 2023 оны төсвийн төсөлд тусгагдаагүй МУС, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны ажлын алба, МУС, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны ажлын алба, МУС, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны ажлын албадын төсөв сайдын багцад тайлагнасан. Зорилтот түвшний шалгуур үзүүлэлт өгүүлбэрээр батлагдсан. Жнь: Төлөвлөсөн хугацаанд 100 хувь хийгдсэн байх, MNS-ISO 9001:2016 стандартад нийцэж ажилласан.

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧДЫН ХӨТӨЛБӨР АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛСАН ТӨСӨВ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Төсвийн тухай хуулийн дагуу орон нутгийн төсвийн 21⁶ ерөнхийлөн захирагч нарын 2024 онд хэрэгжүүлэх 495 хөтөлбөр, 589 хөтөлбөрийн хүрэх үр дүнд нийт 717 чанарын болон тоон шалгуур үзүүлэлтийг тухайн аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчийн хурлын тогтоолоор баталсан. Тайлант хугацаанд 483 хөтөлбөрийн 578 үр дүн нь 85% хүртэл гүйцэтгэлтэй, 4 хөтөлбөрийн 4 үр дүн нь 85%-100%-ийн гүйцэтгэлтэй, 8 хөтөлбөрийн 7 үр дүн нь 100%-с дээш гүйцэтгэлтэй байна.




Зураг 5 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын 2023 оны хөтөлбөр, арга хэмжээний тайлангийн үзүүлэлт

Хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхээр 2024 оны эхний хагас жилд 5.780.6 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 61 хувь буюу 3,513.8 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй. Үүнээс 85 болон түүнээс

⁶ Хөтөлбөр, арга хэмжээний 2024 оны хагас жилийн тайланд Төв аймаг нэгтгэгдээгүй тул нийт 21 төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланг цаашид дурдана.

дээш хувийн төсвийн гүйцэтгэлтэй 14 хөтөлбөрт нийт 320.9 тэрбум төгрөг төлөвлөгдсөнөөс 320.5 тэрбум төгрөг зарцуулагдсан буюу 87 болон түүнээс дээш хувийн гүйцэтгэлтэй байна.

ХӨТӨЛБӨР



Орон нутгийн төсвийн 21 ерөнхийлөн захирагчийн жилийн эцсийн санхүүгийн тайлангаар нийт 495 хөтөлбөр батлагдсанаас давхардаагүй тоогоор 75 хөтөлбөрт хуваарилагдсан байна. Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчид нь улсын төсөвтэй харьцуулахад олон тооны хөтөлбөртэй, түүний дагуу төсөв нь хуваарилагддаг онцлогтой. Бүх төсвийн ерөнхийлөн захирагч 10-аас дээш тооны хөтөлбөртэй бөгөөд үүнээс 16 төсвийн ерөнхийлөн

Зураг 6 Орон нутгийн төсвийн захирагч нь 20 ба түүнээс дээш тооны хөтөлбөртэй байна.
төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрийн тоо

Хамгийн цөөн хөтөлбөртэй 16 хөтөлбөртэй 3 аймаг (Баян-

Өлгий, Баянхонгор, Говь-Алтай), хамгийн олон хөтөлбөртэй Нийслэл бөгөөд 46 хөтөлбөртэй. Үүнд аймгууд хөтөлбөрөө батлахдаа бодлого чиг үүрэг болон төсвийн хуваарилагдсан хөтөлбөрийг баримтлах ялгаатай зарчмуудыг баримталж байгаагаас хөтөлбөрийн ялгаатай байдал үүсэхэд нөлөөлж байна. Орон нутгийн төсвийн хөтөлбөр, тэдгээрийн хүрэх үр дүнг ялгаатай байдлаар төлөвлөж, хэрэгжүүлж байгаа нь орон нутгийн ялгаатай байдлыг бий болгож буй бус төсвийн үр дүнг төлөвлөх арга зүйг ашиглахгүй байх, хөтөлбөр үр дүнгийн ач холбогдлыг тооцохгүй байх, тогтвортой удирдлагыг хэрэгжүүлэхгүй байгаагаар шууд холбоотой байна. Орон нутгийн 2024 оны төсөвт батлагдсан нийт 72 хөтөлбөрийг аймгуудад хэрхэн хуваарилагдсан байдлыг авч үзвэл:

1. Нийт 3 хөтөлбөр (орон нутгийн гүйцэтгэх засаглалыг хэрэгжүүлэх, нийгмийн халамж, Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа) нэг аймагт 2-оос дээш удаа ашиглагдсан байна. Энэ нь тухайн аймгууд төсвийн хавсралтыг бэлтгэх явцдаа харьяа байгууллагын үйл ажиллагааны үр дүнг нэгтгэх бус тус тусад нь мөр болгон давтаж оруулж байгаагаар холбоотой бөгөөд цаашид нэг аймаг нэг хөтөлбөртэй хамаарах хөтөлбөрийн үр дүн, үйл ажиллагааг нэгтгэн боловсруулж баталж байх шаардлагатай юм.

2. Бүх аймаг, нийслэлд зарцуулах төсвийн эх үүсвэртэй бөгөөд хуулийн дагуу⁷ засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагаар төлөөлөх хэрэгжүүлэх нийтлэг байдаг


⁷ Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /шинэчилсэн найруулга/ 27 дугаар зүйл. Нэгжийн удирдлагаар төлөөлөн гүйцэтгүүлэх төрийн чиг үүрэг

хөтөлбөрүүд зарим аймгуудад дутуу батлагдаж байна. Энэ нь мөн аймгийн хэмжээнд төсвийн үр дүнгийн хавсралтыг боловсруулах явцад мэдээлэл дутуу, хангалттай боловсруулалт, хяналт шинжилгээ хийхгүй байгаатай холбоотой юм. Жишээлбэл: Ерөнхий боловсрол, сургуулийн өмнөх боловсрол, мэргэжлийн боловсрол, соёл урлаг, биеийн тамир спорт, эмнэлгийн тусламж үйлчилгээ, насан туршийн боловсрол зэрэг хөтөлбөрүүд нь хэд хэдэн аймгуудад ялгаатай байдлаар дутуу батлагдсан. Жилийн эцэст төсвийн гүйцэтгэл, түүний хөтөлбөр, арга хэмжээний тайланг боловсруулахад эдгээр хөтөлбөрүүдэд бүх төсвийн ерөнхийлөн захирагч нарт төсөв хуваарилагдсан байдаг учраас хүрэх үр дүнгүй, хэмжих боломжгүй зэрэг хүндрэлүүд бий болдог байна.

3. Орон нутгийн төсвийн хүрээнд хөтөлбөр, арга хэмжээг тодорхойлоход төвөгтэй бөгөөд аймгууд ялгаатай байдал үүсгэж байгаа төсөв бол хөрөнгө оруулалтын төсөвлөлт байна. Хөрөнгө оруулалтын арга хэмжээ нь төсөл арга хэмжээгээр тухайн аймгийн хэрэгжүүлж байгаа аль нэг хөтөлбөрт хуваарилагдах боломжтой боловч нэгдсэн аргачлал байхгүй, төсөв хэлэлцэж батлах хугатай бага тул боловсруулалт хийхэд хүндрэл учирдаг байна. Иймд зарим аймгууд хөрөнгө оруулалтын төсвийг “Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт”, “Зорилтот хөрөнгө оруулалт”, “Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт”, “Ангилагдаагүй бусад” гэж ялгаатай байдлаар нэршиж баталсан байна. Иймд цаашид хөрөнгө оруулалтын төсвийн хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлт, төсөвлөлтөд хэрхэн тооцож оруулах талаар нэгдсэн зарчим, арга зүйтэй болох шаардлагатай байна.

4. Орон нутгийн 2024 оны жилийн эцсийн хөтөлбөр, арга хэмжээний тайланд зөвхөн нэг аймагт ашиглагдсан нийт 36 хөтөлбөр байгаа бөгөөд энэ нь нийт хөтөлбөрийн 50 хувь нь буюу хагас нь байна. Үүнд хэд хэдэн шалтгаанууд байгаа бөгөөд хамгийн түгээмэл нэг шалтгаан бол аймгууд хөтөлбөрийн нэрийг ялгаатай байдлаар нэрших, товчлох, өөрсдөө өөрчлөн найруулах, үг, нэр дутуу орхих техникийн алдаа зэрэг хууль эрх зүйгээр баталгаажсан нэршил ашиглахгүй, төрийн байгууллагын албаны бичиг баримтын стандарт мөрдөхгүй зэрэгтэй уялдаатай боловсруулалт, хяналт дутуугаас шалтгааж байна. Жишээлбэл: бичиг хэргийн стандартын хувьд алдаатай “Гадаадын зээл тусла-р хэр-х ТХ”, “Төрийн нийтлэг бусад үйлч СШин”, хөтөлбөрийн албан ёсны нэрийг ашиглахгүй товчилсон болон өөрчлөн найруулсан нэрс ашиглаж байгаа “Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид”, “Цагдаа” зэрэг хөтөлбөрийн нэр бус тухайн үйл ажиллагаа чиглэсэн товч нэрийг ашиглаж байна. Иймд орон нутгийн ялгаатай хөгжил, үйл ажиллагаатай холбоотой бус нийтлэг чиг үүргийн хөтөлбөрийн жишиг нэршил, хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлтийн жишгийг бий болгох шаардлагатай.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН



Орон нутгийн төсвийн 21 ерөнхийлөн захирагчийн жилийн эцсийн санхүүгийн тайлангаар нийт 589 хөтөлбөрийн хүрэх үр дүн батлагдсан. Нэг төсвийн ерөнхийлөн захирагч дунджаар 2 хөтөлбөрийн үр дүнтэй байгаа бол нийт 22 төсвийн ерөнхийлөн захирагчийн 17 нь 20-оос дээш тооны хөтөлбөрийн хүрэх үр 2024 онд баталсан байна.

Хамгийн олон буюу 47 хөтөлбөрийн үр дүнтэй Нийслэл, Өвөрхангай аймаг, хамгийн цөөн нь 19 буюу Архангай аймаг байна.

Зураг 7 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн тоо

Хөтөлбөрийн хүрэх үр дүнг “Тухайн хөтөлбөрийн хүрээнд төлөвлөсөн өөрчлөлтийг хэмжиж болохуйц үр

дүн байдлаар бичнэ. Нэг хөтөлбөрийн хүрээнд хэд хэдэн үр дүнд хүрэхээр тодорхойлж болно” гэж заасан бөгөөд тодорхойлох хүрээнд:

1. Салбарын эсвэл эрхлэх ажлын хүрээнд тулгарч байгаа асуудлыг шийдэх стратегийн зорилтыг агуулах, товч тодорхой, нэг утгыг илэрхийлэх;
2. Тодорхой шийдвэр гаргахад чухал мэдээллийг илэрхийлэх;
3. Гүйцэтгэлийг хэрэгжүүлэгч ажилтан, албан хаагч тус үзүүлэлтийг тодорхойлоход оролцсон байх, тэдний саналыг тусгах;
4. Зөвхөн ач холбогдолтой гол үр дүнг тодорхойлох (зөвхөн хэмжиж болох үзүүлэлтүүд, хийх ажил эсвэл процессыг тоочихгүй байх) зэрэг шаардлагыг тавьсан бөгөөд үүнийг хөтөлбөр тус бүрийн хүрээнд нарийвчилсан судалгаа хийж дүгнэлт хийх шаардлагатай юм.

Хүрэх үр дүнг тодорхойлох талаар дараах 4 үндсэн зарчим баримтлахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт зөвлөмж болгосон бөгөөд тус зөвлөмжийн хүрээнд нийт 589 хөтөлбөрийг дараах байдлаар үнэллээ.

Зарчим	Хангасан	Эзлэх хувь
Хаана хэрэгжих (байршил)	129	22%
өөрчлөлтийг хэн хүртэх (үр шим хүртэгч, оролцогч тал)	277	47%
юуг өөрчлөхөөр зорьж байгааг,	436	74%
хүлээгдэж буй өөрчлөлтийн чиглэл (нэмэгдүүлэх/бууруулах)	512	87%

Нийт 589 үзүүлэлтийн шаардлагыг хангасан эсэхийг тооцоход “юуг өөрчлөхөөр зорьсон” үзүүлэлт хангалттай хангагдсан буюу 87 хувь байна. Энэ нь хөтөлбөрийн үр дүнд тухайн хөтөлбөрийг гол хэмжих зүйл болон хүчин зүйлийг дурдсан тул шаардлага хангаж байна. Харин бусад үзүүлэлтүүд улсын төсвийн нэгэн адил хангалтгүй байгаа бөгөөд “товч тодорхой” байх зарчим ч мөн хангагдахгүй байна. Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрийн хүрэх үр дүн нь цаашид сайжруулах шаардлагатай дараах нийтлэг алдаанууд байна. Үүнд:

1. Хөтөлбөрийн нэр, хөтөлбөрийн хүрэх үр дүн адилхан байх.
2. Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүнд төсөл арга хэмжээний тоог бичих
3. “Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байх”, “Санхүүжилт хийсэн байх”, “Хууль тогтоомжид нийцсэн байх” гэх мэт ерөнхий, хүрэх үр дүн тодорхойгүй байдлаар томъёолох.
4. Хөтөлбөрийг хэт ерөнхий байдлаар томъёолноос шалтгаасан нэг хөтөлбөрийн хүрэх үр дүн хэт олон байх. Үүнд хорь ба түүнээс дээш хүрэх үр дүнтэй 19 аймгийн нийт 22 хөтөлбөр байна.


Иймд цаашид хөтөлбөрийн үр дүнг төлөвлөхдөө удирдамжийн зарчим, шаардлагыг хатуу мөрдөх, түүнийг хянаж шалгаж, нэгтгэх шаардлагатай байна.

ХӨТӨЛБӨРИЙН ТӨСӨВ, ГҮЙЦЭТГЭЛ

Монгол Улсын 2024 оны батлагдсан төсвийн дагуу орон нутгийн төсвийн нийт 22⁸ төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад нийт 5.8 их наяд төгрөг батлагдсан бөгөөд эхний хагас жилд 12.7 их наяд хуваарилагдсан. Хагас жилийн гүйцэтгэлээр 3.5 их наяд төгрөг буюу 61 хувийн гүйцэтгэлтэй санхүүжсэн байна. Үүнд: нийт 8 аймгийн төсвийн гүйцэтгэл 70 буюу түүнээс дээш хувийн гүйцэтгэлтэй байгаа ба үүнээс хамгийн өндөр гүйцэтгэлтэй аймаг нь 78 хувийн гүйцэтгэлтэй Увс аймаг байна. Энэ нь цаашид эдгээр төсвийн хөтөлбөрүүдийн үр дүнтэй болон үр ашигтай хэрэгжсэн байх нөхцлийг бүрдүүлэх юм.

⁸ Төсвийн гүйцэтгэлийн мэдээлэлд хөтөлбөр, арга хэмжээнд нэгтгэгдээгүй Төв аймгийг оруулан тайлагнасан.

Монгол улсын 2024 оны төсвийн хагас жилийн хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнгийн тайлан




Зураг 8 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсөв, гүйцэтгэл, гүйцэтгэлийн хувь /аймгаар, тэрбум төгрөгөөр/

Нийт 75 хөтөлбөрийн төсвийн гүйцэтгэлээр ангилж үзэхэд 6 хөтөлбөр буюу 8 хувь нь 100 хувийн гүйцэтгэлтэй байна. Эдгээр бүрэн санхүүжиж хэрэгжсэн хөтөлбөрт оногдох нийт төсвийн гүйцэтгэл нь 313.2 тэрбум буюу нийт төсвийн 5 хувь оногдож байна. Гүйцэтгэл багатай буюу 50 хувиас бага гүйцэтгэлтэй 14 хөтөлбөрт ногдох төсвийн гүйцэтгэл 501.7 тэрбум төгрөг буюу 9 хувь байна.


Нийт 75 хөтөлбөрөөс “Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага, үйл ажиллагаа” хөтөлбөр нь бүх аймаг, нийслэлд байдаг төрийн удирдлагыг хэрэгжүүлэх байгууллагуудын үйл ажиллагааны зардал болон зарим аймагт чиг үүргийг бүх төсвийг хуваарилснаас шалтгаалан хамгийн их төсөвтэй ба нийт төсвийн 43 хувь буюу 2.5 тэрбум төгрөг хуваарилсан. Тус хөтөлбөрийн гүйцэтгэл 1.8 их наяд буюу 73 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан.

Монгол улсын 2024 оны төсвийн хагас жилийн хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнгийн тайлан




Зураг 9 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсөв, гүйцэтгэл, гүйцэтгэлийн хувь /хөтөлбөрөөр, сая төгрөгөөр/

ХӨТӨЛБӨРИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ




Орон нутгийн төсвийн нийт 21 төсвийн ерөнхийлөн захирагчдын хөтөлбөрт нийт 717 шалгуур үзүүлэлт батлагдсан. Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын хувьд шалгуур үзүүлэлтийн тоо харьцангуй ялгаатай байгаа бөгөөд 20-62 шалгуур үзүүлэлттэй байна. Хамгийн олон буюу 62 шалгуур үзүүлэлттэй аймаг Ховд аймаг, хамгийн цөөн буюу 20 шалгуур үзүүлэлттэй аймаг нь Баянхонгор аймаг байна. Хөтөлбөр, болон хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн судалгаатай харьцуулахад шалгуур үзүүлэлтийн харьцуулалт

ялгаатай байгаа нь хөтөлбөр, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт нь хоорондоо уялдаа багатай байгааг мөн харуулж байна.



Нийт 717 шалгуур үзүүлэлтийн 421 нь буюу 59 хувь нь чанарын, 236 буюу 41 хувь нь тоон шалгуур үзүүлэлт



батлагдсан байна. Харин нийт шалгуур үзүүлэлтийн 97 хувь буюу 696 нь өсөх хандлагатай төлөвлөгдсөн.

Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг төсвийн хөтөлбөрийн үр дүнг хоёроос доошгүй, таваас ихгүй тоон эсвэл чанарын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээр хэмжихийг зөвлөдөг. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 495 хөтөлбөрийг харьцуулахад нийт 455 хөтөлбөр тус бүр 1 шалгуур үзүүлэлттэй, 29 хөтөлбөр 2 шалгуур үзүүлэлттэй, 11 хөтөлбөр 3 шалгуур үзүүлэлттэй ба удирдамжид заасан шалгуурыг хангаж байна.

Шалгуур үзүүлэлтийн тоо хэдий цөөхөн байгаа нь нэг талаар оновчтой байх ёстой боловч орон нутгийн хувьд шалгуур үзүүлэлтийг хэт ерөнхий байдлаар хөтөлбөр, хүрэх үр дүнтэй ижил байдлаар тогтоох нь түгээмэл байна. Жишээлбэл: зарим аймгууд “бүрэн санхүүжсэн байна”, “зардал төлөгдсөн байна”, “гүйцэтгэлийн хувь”, “Төлөвлөсөн арга хэмжээг бүрэн санхүүжүүлэх”, “хамрагдсан байгууллагын санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулалтын хувь” гэх мэт шууд санхүүжилттэй уялдуулах, “хэвийн үйл ажиллагааг хангасан байх”, “Үйл ажиллагааны хэвийн, жигд байдал” гэх мэт тухайн хөтөлбөрт хамаарах байгууллагын үйл ажиллагаатай уялдуулах зэрэг нийтлэг байдал, шалгуур үзүүлэлтийг тодорхойлох талаар боловсруулалт хийхгүй, нэг аймгийн бүх хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт “Хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлсэн байна” гэж тогтоосон нь зарчим удирдамж баримтлахгүй байх гэх мэт дутагдалтай талууд байна.

Орон нутгийн төсвийн хөтөлбөр, арга хэмжээний тайлан нэгтгэхэд гарсан зарим хүндрэлийн жишээнээс:

1. Нийтлэг аймгуудын хувьд Төсвийн тухай хуулийн дагуу цаг хугацаанд тайлангаа багтааж өгөхдөө хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн тайлан нэгтгэн боловсруулахад 1-2 хоногийн нэмэлт хугацааг зарцуулж байсан. Энэ нь орон нутагт төрийн байгууллага, албан хаагчдын ажлын уялдаа болон тогтвортой байдалтай шууд холбоотой бөгөөд бодлого төлөвлөлт, хяналт шинжилгээний болон бусад холбогдох чиг үүргийн байгууллагууд хөтөлбөр, арга хэмжээний тайлангийн талаар ойлголт, оролцоо бага, ач холбогдол өгөхгүй байна.
2. Сангийн сайдын 2023 оны 255 дугаар баталсан тушаалын хэрэгжилт хангалтгүй бөгөөд тайланг албажуулах ажлыг Сангийн яаманд нэгтгэхээс өмнө хийж ирэхгүй байх, тайлангийн хуулийн хугацаа дууссаны дараа ч албажуулах ажил үргэлжилж байсан. Иймд цаашид холбогдох тушаал шийдвэрийн олон нийтэд түгээх, таниулах үй ажиллагааг хийх шаардлага байна.
3. Орон нутгийн хувьд улсын төсвийн ерөнхийлөн захирагчдаас ялгаатай нь төсвийн нэг дүгээр хавсралт буюу хүрэх үр дүнгийн хавсралт хяналт, оролцоо сул байгаагаас хөтөлбөр, түүний хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийн боловсруулалт хангалтгүй байна. Иймээс тэдгээрийг техникийн болон уялдааны хувьд олон ялгаатай байдлаар тогтоосон нь цаашид үр дүнг хэмжих, тайлагнах боломжийг хязгаарлаж байсан.
4. Орон нутгийн төсвийг төлөвлөх үе шатнаас эхлэх хөтөлбөр, үр дүнгийн тайлангийн боловсруулалт хангалтгүй байгаагаас төсвийн төсөлд сумдын үр дүн нэгтгээгүй, аймгийн ИТХ-аар төсөв батлах явцад сумдын төсөв болон үр дүнгийн мэдээлэл тусгагдаагүй нь аймгийн хэмжээнд төсвийн санхүүжилтээр хэрэгжсэн хөтөлбөрийн үр дүнг бүрэн илэрхийлэхгүй байна.

ТӨСВИЙН ХӨТӨЛБӨРИЙН ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын хөтөлбөр, үр дүнгийн төлөвлөгөө улсын төсвийн хувьд тухайн жилийн төсвийн тухай хуулийн нэгдүгээр хавсралтаар, аймаг, нийслэлийн орон нутгийн төсвийн хувьд ИТХын тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталдаг. Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын хувьд 3 хөтөлбөр хоорондоо давхацдаг бол орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын хөтөлбөр, хоорондоо ижил төстэй мөн зарим хөтөлбөрүүд улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөртэй давхацдаг. Мөн аймаг, нийслэл бүр хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг ялгаатай баталж байна. Иймд хөтөлбөр тус бүрээр хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг 2024 онд баталсан ялгаатай байдал болон түүнийг оновчтой тогтоох саналыг боловсрууллаа. Саналыг боловсруулахад дараах зарчмыг баримтлав. Үүнд:

- Саналаа боловсруулахдаа нэгээс олон төсвийн ерөнхийлөн захирагчид хамаарах хөтөлбөрийн хүрэх үр дүн болон шалгуур үзүүлэлтийг бүгдийг оруулах, орон нутгийн бүх ерөнхийлөн захирагчид хамаарах хөтөлбөрийн хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг ижил төстэй шинжээр нэгтгэх;
- Системд аль болох цөөн тооны, товч тодорхой, хэмжиж болохуйц, бүх төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн үйл ажиллагаа эх сурвалжид суурилан тодорхойлох боломжтой хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлтийг боловсруулан сонгох;
- Тайлант хугацаанд төсөв батлагдсан боловч хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлтийг батлагдаагүй хөтөлбөрүүдийг ерөнхий байдлаар дүгнэх боломжтой үр дүн, шалгуур үзүүлэлт боловсруулах;
- Бүх аймаг, нийслэл тухайн хөтөлбөрт гүйцэтгэл, хэрэгжилтийн үр дүн оруулах боломжтойгоор хөтөлбөрийн үр дүн болон шалгуур үзүүлэлтийг сонгосон.
- Цаашид жил бүрийн батлагдсан төсөвтэй уялдуулан хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг шинэчлэх, өөрчлөх, нэмэх, хасах боломжтой.
- ТЕЗ нэгээс дээш хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуураас өөрт хамаарах тоогоор сонгох бөгөөд сонголтод үндэслэн систем уян хатан тооцоог өөрчлөх, оролцооны хувийг шинэчлэх боломжтой.

Тус саналын дагуу Сангийн яамны санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нэгдсэн системийн “хөтөлбөр, үр дүнгийн тайлан”-ийн модулд 2024 оны төсвийн тайланг хүлээн авахад бэлтгэх өгөгдөл болгон оруулсан.

Хөтөлбөр тус бүрээр хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийн өнөөгийн байдлыг тусгасан бөгөөд хөтөлбөрийн 5 орон тоотой дугаарын дарааллаар эрэмбэлэв.

70101 - МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Үзүүлэлт	2024 онд батлагдсан	Санал болгосон
Хөтөлбөрийн хүрэх үр дүн	1	1
Шалгуур үзүүлэлт	1	1

Хамаарах төсвийн ерөнхийлөн захирагч: 1 /Ерөнхийлөгчийн тамгын газар/

Хөтөлбөрийн үр дүн: “Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан үндэсний хөтөлбөр, чуулган, форум, уулзалт, хөтөлбөрт арга хэмжээ болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн төрийн айлчлал, бусад арга хэмжээг хэрэгжүүлнэ”.

Шалгуур үзүүлэлт: “Хэрэгжилтийн биелэлт”. Тус шалгуур үзүүлэлтийн биелэлтийн хувиар хэмжих бөгөөд өсөх эрэмбэтэй шалгуур үзүүлэлт.

Системд тусгасан байдал: Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын болон цөөн тооны төсвийн ерөнхийлөн захирагчид хамаарах хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг бүрэн оруулах зарчмын дагуу хуулиар батлагдсан хөтөлбөрийн хүрэх үр дүн шалгуур үзүүлэлтийг хэвээр үлдээсэн.

Санал: Цаашид хөтөлбөр хэрэгжүүлснээр гарах үр нөлөө, үр дүнд суурилан шалгуур үзүүлэлтийг сайжруулах шаардлагатай.

70102 - ХУУЛЬ ТОГТООХ, ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭНД ХЯНАЛТ ТАВИХ

Үзүүлэлт	2024 онд батлагдсан	Санал болгосон
Хөтөлбөрийн хүрэх үр дүн	4	4
Шалгуур үзүүлэлт	4	4

Хамаарах төсвийн ерөнхийлөн захирагч: 2 /ЕТГ, УИХ/

Хөтөлбөрийн үр дүн: Хөтөлбөр болон хөтөлбөрийн үр дүнг төсвийн ерөнхийлөн захирагч бүр ялгаатай тогтоосон бөгөөд тус бүр хоёр хүрэх үр дүн тодорхойлсон.

Төсвийн ерөнхийлөн захирагч	Хөтөлбөрийн нэр	Хөтөлбөрийн хүрэх үр дүн	Шалгуур үзүүлэлт	Эх сурвалж	Шалгуур үзүүлэлтийн эрэмбэ
ЕРӨНХИЙ ЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗАР	Дотоод, гадаад шуурхай мэдээллийн үйл ажиллагаа	Монгол Улсын иргэд, олон нийт, байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгслийг дотоодод болон гадаадын улсад болж байгаа үйл явдлын мэдээллээр тогтмол, шуурхай хангана.	Эх хэл дээр бэлтгэн гаргах мэдээ, мэдээлэл	Байгууллагын хагас жилийн ажлын тайлан	Өсөх
		Монгол Улсын гадаад, дотоод бодлого, түүх, өв, соёл, уламжлал, хөгжил дэвшлийг гадаадын улсад тогтмол мэдээлж сурталчлан таниулна.	Гадаад хэл дээр бэлтгэн гаргах мэдээ, мэдээлэл	Байгууллагын хагас жилийн ажлын тайлан	Өсөх
УЛСЫН ИХ ХУРАЛ	Хууль тогтоох, хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих	Хууль тогтоомжийн төслийг Байнгын хорооны болон Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулна.	Хууль тогтоомжийн төсөл	Улсын Их Хурлын Тамгын газрын жилийн үйл ажиллагааны тайлан,	Өсөх
		Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үр дагаврын	Хяналтад авах хууль тогтоомж	Улсын Их Хурлын Тамгын газрын жилийн	Өсөх

	үнэлгээ хийж эрх зүйн орчныг сайжруулах нөхцөлийг бүрдүүлнэ.	үйл ажиллагааны тайлан,	
--	--	-------------------------	--

Шалгуур үзүүлэлт: Төсвийн ерөнхийлөн захирагчид үйл ажиллагааны гарцад тулгуурласан шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон бөгөөд ЕТГ нь хөтөлбөрийг хүрэх үр дүн болон төсвийн хөтөлбөрийг уялдаа алдагдаж тодорхойлогдсон.

Системд тусгасан байдал: Холбогдох эрх зүйн баримт бичигт заасан хөтөлбөрийн дагуу тогтоосон хоёр хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлтийг оруулсан. Хоёр шалгуур үзүүлэлтээр тоогоор хэмжигдэх, өсөх эрэмбэтэй шалгуур үзүүлэлт.

Санал: Цаашид хөтөлбөр хэрэгжүүлснээр гарах үр нөлөө, үр дүнд суурилан шалгуур үзүүлэлтийг сайжруулах шаардлагатай.

70103 - ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛЫН УДИРДЛАГА

Үзүүлэлт	2024 онд батлагдсан	Санал болгосон
Хөтөлбөрийн хүрэх үр дүн	1	1
Шалгуур үзүүлэлт	1	1

Хамаарах төсвийн ерөнхийлөн захирагч: 1 /ЗГХЭГ/

Хөтөлбөрийн үр дүн: Хууль тогтоомж, хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангуулна.

Шалгуур үзүүлэлт: Хууль болон журмын хугацаанд тайлагнах бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, төсөл, хөтөлбөр. Тус шалгуур үзүүлэлтийн биелэлтийн тоогоор хэмжих бөгөөд өсөх эрэмбэтэй шалгуур үзүүлэлт.

Системд тусгасан байдал: Холбогдох эрх зүйн баримт бичигт заасан хөтөлбөрийн дагуу тогтоосон хоёр хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлтийг оруулсан.

Санал: Цаашид хөтөлбөр хэрэгжүүлснээр гарах үр нөлөө, үр дүнд суурилан шалгуур үзүүлэлтийг сайжруулах шаардлагатай.

70104 - ЕРӨНХИЙЛӨГЧ, ХУУЛЬ ТОГТООХ БОЛОН ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛЫН УДИРДЛАГЫН СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ

Үзүүлэлт	2024 онд батлагдсан	Санал болгосон
Хөтөлбөрийн хүрэх үр дүн	-	1
Шалгуур үзүүлэлт	-	1

Хөтөлбөрийн үр дүн: Үйл ажиллагааны хэрэгжилт.

Шалгуур үзүүлэлт: Хэрэгжилтийн биелэлт. Тус шалгуур үзүүлэлтийн биелэлтийн хувиар хэмжих бөгөөд өсөх эрэмбэтэй шалгуур үзүүлэлт.

Системд тусгасан байдал: Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлтийг батлагдаагүй хөтөлбөрт ерөнхий байдлаар дүгнэх боломжтой үр дүн, шалгуур үзүүлэлт боловсруулсан.

Санал: Цаашид төсөв хуваарилагдсан хөтөлбөрт түүгээр дамжуулан гарах үр дүнтэй холбож оруулах шаардлагатай.

70105 - ОРОН НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ ЁСНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Үзүүлэлт	2024 онд батлагдсан	Санал болгосон
Хөтөлбөрийн хүрэх үр дүн	33	2
Шалгуур үзүүлэлт	47	2

Тус хөтөлбөр нь орон нутгийн өөрөө удирдах байгууллага буюу Иргэдийн төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагааны төсвийг хамааруулдаг бөгөөд бүх аймаг, нийслэлд тухайн хөтөлбөр нь жил бүр батлагддаг. Орон нутгийн хувьд хөтөлбөрийн хүрэх үр дүн болон шалгуур үзүүлэлт мөн харилцан адилгүй байна.

Хөтөлбөрийн үр дүн: Тус хөтөлбөрт 12 аймаг нэг хүрэх үр дүн баталсан бол 4 аймаг 2, 3 аймаг 3, нэг аймаг 4 хүрэх үр дүнтэй баталсан ба нийт 22 хүрэх үр дүн батлагдсан ба “Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэр нь орон нутгийн хөгжлийг дэмжихэд чиглэнэ” хөтөлбөрийн хүрэх үр дүн 3 аймагт давхардсан байна. Иймд тус хөтөлбөрийн хүрэх үр дүнг ИТХ болон түүний холбогдох эрх зүйн хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагааны үр дүнд бий болох үр дүн, үйл ажиллагаанд тулгуурлах шаардлагатай.

Шалгуур үзүүлэлт: Хэрэгжилтийн биелэлт. Тус шалгуур үзүүлэлтийн биелэлтийн хувиар хэмжих бөгөөд өсөх эрэмбэтэй шалгуур үзүүлэлт.

Тус хөтөлбөрийн хувьд нэг хөтөлбөрт ногдох шалгуур үзүүлэлтийн тоо 1-5 байна. Нийт 47 шалгуур үзүүлэлт байгааг ангилж үзэхэд төлөвлөгөөний хэрэгжилт 13, хуралдааны тоо 11, шийдвэрийн хэрэгжилт 4, шийдвэрийн тоо 3 байна. Иймд нийтлэг байдлаар хуралдааны тоо болон шийдвэрийн тоо, хэрэгжилтийг нийтлэг шалгуур үзүүлэлтээр сонгох боломжтой байна.

Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа (70105) хөтөлбөрийн хүрэх үр дүн 2024 оны батлагдсан байдлаар

Системд тусгасан байдал: Хөтөлбөрт нийтлэг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үр дүн болон нэмэлтээр тус хөтөлбөрөөр дамжиж хэрэгждэг цагаатгах ажлын чиг үүргийг багтаасан байдлаар хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг багтаасан.

Хөтөлбөрийн хүрэх үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Эх сурвалж	Оролцооны хувь	Шалгуур үзүүлэлтийн эрэмбэ
Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэр нь орон нутгийн хөгжлийг дэмжихэд чиглэнэ	Иргэдийн төлөөлөгчдийн шийдвэрийн хэрэгжилт	хувь	Үйл ажиллагааны албан ёсны тайлан	50%	Өсөх
Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах хуулийг сурталчлах, иргэдийг мэдээллээр хангана	Үйл ажиллагааны хэрэгжилт	хувь	Үйл ажиллагааны албан ёсны тайлан	50%	Өсөх

Санал: Цаашид төсөв хуваарилагдсан хөтөлбөрт түүгээр дамжуулан гарах үр дүнтэй холбож оруулах шаардлагатай.

70106 - ОРОН НУТГИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛЫН УДИРДЛАГА

Үзүүлэлт	2024 онд батлагдсан	Санал болгосон
Хөтөлбөрийн хүрэх үр дүн	92	2
Шалгуур үзүүлэлт	118	2

Тус хөтөлбөрт аймгийн болон сумдын засаг даргын тамгын газар, түүний чиг үүргийн байгууллага, алба нэгжийн үйл ажиллагааны болон хөтөлбөрийн зардал хамаарч, бүх аймаг, нийслэлд тухайн хөтөлбөр нь жил бүр батлагддаг. Орон нутгийн хувьд хөтөлбөрийн хүрэх үр дүн болон шалгуур үзүүлэлт мөн харилцан адилгүй байна.

Хөтөлбөрийн үр дүн: Тус хөтөлбөрт 12 аймаг нэг хүрэх үр дүн баталсан бол бусад аймгууд 2-17 хүртэлх үр дүн баталсан. Үүнээс “Орон нутгийн гүйцэтгэх засаглалын байгууллагын үйл ажиллагааны хэвийн, жигд байдал хангагдсан байна” хөтөлбөрийн хүрэх үр дүн 10 аймагт, “Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх” хөтөлбөрийн үр дүнд 9 аймагт давхардсан байна.



Тус хөтөлбөрт батлагдсан нийт 92 хүрэх үр дүнг чиглэлээр нь тоймлон судалж үзэхэд салбарын бодлого буюу эрүүл мэнд, эрчим хүч, байгаль орчин, гамшгаас сэргийлэх, соёл, боловсрол, хүүхэд залуучуудын зэрэг салбарын бодлогод хамаарах хөтөлбөрийн үр дүн хамгийн олон буюу 27 байгаа бол ЗДТГ, түүний харьяа байгууллагуудын үйл ажиллагааны удирдлага, бодлого хэрэгжилт 21, хөрөнгө оруулалтад хамаарах үр дүн 21 байна. Харин тус хөтөлбөрөөр дамжуулан орон нутагт,

нийгэм, хүн ардад үзүүлэх үр дүнг буюу төрийн үйл ажиллагааны гарах үр дүнг илэрхийлсэн 10 хөтөлбөр үр дүн байна.

Орон нутгийн гүйцэтгэх засаглалын үндсэн үүрэг нь тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд засгийн газраас баталсан хууль, журам, бодлогыг хэрэгжүүлэх, иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх, нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд дэмжлэг үзүүлэх зэрэгт чиглэгддэг. Энэ засаглалын үүрэг нь олон талт бөгөөд доорх чиглэлүүдээр ангилагдана:

- Төрийн бодлогын хэрэгжилт: Орон нутагт хууль тогтоомж, төрийн бодлогын хэрэгжилтийг хангах, зохицуулалт хийх, хяналт тавих үүрэгтэй.
- Иргэдийн үйлчилгээ: Орон нутгийн иргэдэд эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамж, зам тээвэр, эрчим хүч, ус хангамж зэрэг төрийн үйлчилгээг хүргэх.
- Эдийн засгийн хөгжил: Орон нутагт эдийн засгийн өсөлт, бүтээмжийг дэмжих, орон нутгийн төсөв санхүүг үр ашигтай ашиглах, хөрөнгө оруулалт татах, жижиг дунд бизнесийг дэмжих.
Тус судалгааны тайлан болон Монгол Улсын 2024 оны хагас жилийн бүх төсвийн ерөнхийлөн захирагчдын тайланд үндэслэн дараах санал дүгнэлтийг боловсруулсан тул дурдагдсан асуудал болон сайжруулах санал нь аль нэг ТЕЗ-д шууд хамаарахаас илүү бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагчдын түвшинд ашиглагдахаар боловсруулагдсан.

Дүгнэлт	Сайжруулах санал
<ul style="list-style-type: none">Үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлт, төсөвлөлт, тайлагнал, хяналт шинжилгээний үе шатуудад бодлогын болон техникийн олон талт зөвлөх үйлчилгээ хэрэгжүүлсний үр дүнд ахиц гарсан нь өмнөх хийгдэж байсан тайлангийн судалгаа болон тус 2024 оны хагас жилийн тайлантай харьцуулахад харагдаж байна. Цаашид үр дүнд суурилсан төсвийн бүх үе шатанд тасралтгүй сайжруулалт шаардлагатай.	<p>Хөтөлбөр арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнгийн тайлангийн боловсруулах, нэгтгэх үйл явцад сүүлийн хоёр жилийн хугацаанд улсын болон орон нутгийн сонгосон ТЕЗ-ийн багцад судалгаа, шинжилгээ хийгдэж, тодорхой зөвлөмж, саналыг хэрэгжүүлсэн ажилсны үр дүнд тухайн ТЕЗ нарын тайланд ахиц гарсан нь харагдаж байна. Төсвийн тайлагналыг сайжруулахад тухайн үе шатанд ажиллахаар гадна төлөвлөх, төсөвлөх үе шатанд мөн сайжруулалт, шинэчлэл хийх шаардлагатай байна. Иймд үр дүнд суурилсан төсвийн бүх үе шатанд тасралтгүй сайжруулалтыг урт болон дунд хугацаанд хэрэгжүүлж, бүх шатны ТЕЗ-ийн зарцуулсан төсвийн нийгэм, эдийн засаг, хүн ам, орон нутаг, салбартаа гаргасан үр нөлөөгөөр хэмждэг болох нь цаашид төсвийн үр ашгийг хэмждэг болох, үр дүнтэй зарцуулах үндэс суурь нь болох юм.</p>
<ul style="list-style-type: none">Төсвийн тайлагналын бүх үе шатанд хөтөлбөр, үр дүнгийн тайланг хагас жилээр тайлагнах, нэгтгэх, хянах үйл ажиллагаа төлөвшөөгүйгээс шалтгаалан техник алдаа, зөрүү ихтэй байна.	<p>Хөтөлбөр, үр дүнгийн тайлан нь Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн захирагчийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн нэг бүрэлдэхүүн хэсэг тул хуульд заасан хугацаанд бусад тайлангийн адил үнэн зөв, чанартай боловсруулж, тайлагнах, нэгтгэн дүгнэх ажлыг зүгшрүүлэх шаардлагатай байна. Тус тайлан нь 2023 оноос эхлэн тайлангийн журам, аргачлалтай болсон учраас хагас болон бүтэн жилээр боловсруулж, хянаж, нэгтгэх үйл ажиллагааг хариуцлагатай тайлагнах шаардлагатай. Цаашид хөтөлбөр, арга хэмжээний</p>

	<p>тайлагналыг цахимжуулж, хүний техник оролцоог багасгаснаар алдааг багасгах, нэгтгэлийг хугацааг багасгах давуу талтай. Иймд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн цахим системд бүрэлдэхүүнд хөтөлбөр, арга хэмжээний цахим системийг ашиглалтад нэвтрүүлэх нь онцгой ач холбогдолтой.</p>
<ul style="list-style-type: none"> Орон нутгийн төсвийг төлөвлөх үе шатнаас эхлэх хөтөлбөр, үр дүнгийн тайлангийн боловсруулалт хангалтгүй байгаагаас төсвийн төсөлд сумдын үр дүн нэгтгээгүй, аймгийн ИТХ-аар төсөв батлах явцад сумдын төсөв болон үр дүнгийн мэдээлэл тусгагдаагүй нь аймгийн хэмжээнд төсвийн санхүүжилтээр хэрэгжсэн хөтөлбөрийн үр дүнг бүрэн илэрхийлэхгүй байна. 	<p>Орон нутгийн төсвийн төлөвлөх, батлах, хуваарилах үе шатанд хөтөлбөр, үр дүнгийн тайланг аймгийн хэмжээнд тооцох арга зүй дутагдаж байна. Монгол Улсын 2024 оны төсвийн төсөл боловсруулах удирдамжид “2.4.2 Аймаг/нийслэлийн болон сум/дүүргийн ИТХ-ын тогтоолын 1 дүгээр хавсралтаар зөвхөн аймгийн эсвэл сумын төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг батлах /сумын төсвийн суурь зарлага, суманд олгож байгаа орлогын шилжүүлэг санхүүгийн дэмжлэгийг оруулахгүй байх/;” гэж тусгасны дагуу аймгууд төсөв батлах болон түүнийг тайлагнах явцад сумдын төсөв, үр дүн ороогүй байна. Төсвийн төсөл боловсруулах үе шатаас эхлэн хөтөлбөрийн хүрэх үр дүнг төсвийн нэгэн адил анхан шатнаас буюу сумдын нэгжээс хүлээн авч нэгтгэхгүй байгаагаас шалтгаалан Аймгийн ИТХ-аар баталж байгаа хөтөлбөр, хүрэх үр дүн, төсвийн хэмжээ зөвхөн аймгийн түвшинд сумдын нөлөөлөл тусгахад цаг хугацаа хангалтгүй, харилцан уялдаагүй байдал үүсдэг. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлт, тайлагнал нь тухайн төсвөөр дамжуулан орон нутгийн олон талын салбарын хэвийн үйл ажиллагааг хангах замаар үр дүн, үр нөлөөг бий болгож байгаа тул орон нутгууд төсвийг төлөвлөх үе шатнаас эхлэн төсвийн хөрөнгөөр хэрэгжих үр дүнг, төсвийн хамт бүрэн төлөвлөж, тайлагнах нь</p>

	<p>зүйтэй. Ингэснээр орон нутаг дах удирдлагыг сайжруулах, тайлагналын үр дүнд тулгуурлан үнэлгээ хийснээр бодлогын төлөвлөлтөд тусгах ач холбогдолтой.</p>
<ul style="list-style-type: none"> Төсвийн хөтөлбөр болон бодлогын баримт бичгийн хөтөлбөр, үр дүнгийн уялдаа хангалтгүй байгаагаас тайлагналд хөтөлбөр дутуу тайлагнагдаж байна. Хөтөлбөр, үр дүнгийн тайлангийн суурь болон зорилтот түвшний мэдээлэл, үндэслэх эх сурвалж, аргачлал тодорхойгүй байгаас үр дүн зөрүүтэй гарах магадлалтай. 	<p>Хөтөлбөр, хүрэх үр дүн болон шалгуур үзүүлэлтийг боловсруулж, төлөвлөх үе шатанд хагас жилээр тооцох боломжгүй төлөвлөж байгаагаас шалтгаалан хагас жилийн биелэлтийг бодитой үнэлэхэд хүндрэлтэй байна. Үүнд нөлөөлж байгаа хүчин зүйлийн нэг нь бодлогын баримт бичиг, түүнд төлөвлөгдсөн арга хэмжээ, үр дүн, зорилт, шалгуур үзүүлэлт нь төсвийн хөтөлбөр, арга хэмжээтэй шууд уялдахгүй байгаатай холбоотой юм. Иймд бодлогын баримт бичгийн уялдааг сайжруулж, хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт бүрийг тооцох аргачлал, эх сурвалжийг тодорхой болгосноор хагас жилээр суурь болон зорилтот түвшнийг тооцох боломж бүрдэнэ.</p>
<ul style="list-style-type: none"> Хөтөлбөр, үр дүнгийн тайлангийн төлөвлөх, төсөвлөх, тайлагнах, хяналт шинжилгээ хийх үе шатанд боловсруулсан арга зүй, зөвлөх үйлчилгээ, журмын танилцуулга, зөвлөх үйлчилгээний үр дүнг түгээн дэлгэрүүлэх шаардлагатай байна. 	<p>Үр дүнд суурилсан төсвийн онол, арга зүйг сайжруулах, улсын болон орон нутгийн төсөвт нэвтрүүлэх чиглэлээр хийгдсэн сургалт, нөлөөлөл, түгээн дэлгэрүүлэх олон талт үйл ажиллагаа хийгдсэн. Гэвч танхимын сургалт тогтмол хийх нөөц бололцоо хомс, цахим гарын авлага, мэдээлэл хүн бүрт хүрээгүй, төрийн албан хаагчдын албан тушаалын тогтворгүй байгаагаас шалтгаалан хөтөлбөр, үр дүнгийн төлөвлөлт, тайлагналын явц шаардлага хангахгүй байна. Иймд хөтөлбөр, үр дүнгийн төсвийн бүх үе шатанд баримтлах зарчим, эрх зүйн баримт бичиг болон цаашид нэвтрүүлэх цахим системийг бүх төсвийн захирагчийн холбогдох төрийн албан хаагчдыг чадавхжуулах, тогтмолжуулах талаар анхаарах шаардлагатай.</p>

<ul style="list-style-type: none">Тайланг хариуцаж нэгж, албан хаагч тодорхойгүй байгаагаас шалтгаалан тайлан удаашралтай, эх сурвалж тодорхойгүй, хариуцлагагүй байдал үүсэж байна.	<p>Орон нутагт хөтөлбөр, үр дүнгийн тайлангийн хэрэгжилтэд хамаарах зарим төрийн албан хаагчид ажлын чиг үүрэгт уг тайлантай холбоотой чиг үүрэг тусгагдаагүй нь тухайн албан хаагч уг тайланд ач холбогдол өгөхгүй байх, тайлан чанаргүй боловсруулагдах зэрэг асуудлууд гарч байна. Иймд улсын болон орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчид хөтөлбөр, үр дүнгийн тайлангийн ач холбогдлыг бүх шатанд түгээх, хариуцлагажуулах шаардлагатай.</p>
--	---

ОРОН НУТАГТ ҮР ДҮНД
СУУРИЛСАН НЭГДСЭН
УДИРДЛАГЫГ ХЭВШҮҮЛЭХ НЬ”
СЭДЭВТ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРИЙН
3 ДУГААР ҮЕ ШАТНЫ
ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

2024

ОРОН НУТАГТ ҮР ДҮНД СУУРИЛСАН НЭГДСЭН УДИРДЛАГЫГ ХЭВШҮҮЛЭХ НЬ” СЭДЭВТ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРИЙН 3 ДУГААР ҮЕ ШАТНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Дэмжих хөтөлбөрийн 3 дугаар үе шатны үнэлгээ нь орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын 2024 оны эхний хагас жилийн хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн болон тухайн тайлан боловсруулалт, оролцогчдын мэдлэг зэрэгт үндэслэн үнэлгээ хийх аргачлалын дагуу Сангийн яамны Төрийн сангийн газар болон төслийн нэгжийн төлөөллөөс бүрдсэн үнэлгээний баг үнэлгээ хийв.

Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын 2023 оны эхний хагас жилийн хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнгийн тайлан боловсруулалт нь тус дэмжих хөтөлбөрийн удирдамжийн⁹ дагуу 2024 оны 8 дугаар сарын 1-ээс 30-ны өдрийн хугацаанд нэгтгэн, хянаж, үнэлгээ хийгдсэн.

ОРОЛЦОГЧИД

01

Орон нутгийн 22 төсвийн ерөнхийлөн захирагчаас 20 аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч нар /цаашид баг гэх/ хамрагдсан. Тус үнэлгээнд 20 багийн 114 оролцогчид өрсөлдсөн.

ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

02

Дэмжих хөтөлбөрийн 3 дугаар үе шатны үнэлгээг тайлагналын багаас боловсруулсан аргачлалын дагуу үнэлсэн. Тус аргачлал нь 4 хэсэг, 11 шалгуур үзүүлэлттэй бөгөөд олон улсын balanced score card ийн үнэлгээний зарчим ашиглан бүлэг тус бүрийн эзлэх хувь хэмжээгээр үнэлэв. Дэлгэрэнгүй аргачлалыг хавсралтаар оруулав.

ҮНЭЛГЭЭНИЙ ЯВЦ

03

Дэмжих хөтөлбөрийн тайлагналын үнэлээ нь гурван хэсгээс бүрдсэн.

- Хөтөлбөрт оролцогчдод хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, тайлагналын эрх зүйн орчин, зохион байгуулалт, дэмжих хөтөлбөрийн үнэлгээний талаар мэдээллийг 07 дугаар сарын 03 болон 07 дугаар сарын 25-ний өдөр тус тус зохион байгуулав.
- Оролцогчдын үнэлгээний 4-р хэсэг болох мэдлэгийн ур чадварын тестийг 07 дугаар сарын 25-нд цахим линкээр дамжуулан нэгэн зэрэг шууд зохион байгуулсан.

⁹ Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын дунд зохион байгуулах “Орон нутагт үр дүнд суурилсан нэгдсэн удирдлагыг хэвшүүлэх нь” сэдэвт дэмжих хөтөлбөрийн удирдамж

3. Төсвийн тухай хуулийн¹⁰ дагуу орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын 2024 оны эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэл, хөтөлбөр арга хэмжээний тайлан хүлээн авч, нэгтгэх цагалбарын дагуу тайланг авч нэгтгэсэн.
4. Мэдлэг ур чадварын сорил, хөтөлбөр, арга хэмжээний тайлангийн үзүүлэлтийг хянах, нэгтгэн, зохион байгуулалтын явцыг оролцогч бүрээр үнэлэн нэгдсэн үнэлгээг гаргасан.

ҮНЭЛГЭЭНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Дэмжих хөтөлбөрийн хүрээнд үнэлгээг Сангийн сайдын 2023 оны 225 дугаар тушаалаар баталсан “Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнг тайлагнах журам” болон хавсралтаар баталсан маягтын хүрээнд үнэлсэн. Олон улсын менежментийн үнэлгээ аргачлал болох balanced score card ийн үнэлгээний зарчимд суурилсан бүлэг тус бүрийн эзлэх хувь хэмжээгээр үнэлэв. Хамгийн өндөр үнэлэгдсэн баг 114 оноо, хамгийн муу үнэлэгдсэн баг 29 авах боломжтой. Өөрөөр хэлбэл багуудын үнэлгээ 29-114 -ын хооронд хэлбэлзэж, хамгийн өндөр оноог хамгийн сайн гэж үнэлсэн. Үнэлгээ нийт 4 бүлгийн хүрээнд 4 бүлэг, 11 шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлсэн.

Үнэлгээг 2024 эхний эхний хагас жилийн төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүнд ирүүлсэн хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнгийн тайлан болон дэмжих хөтөлбөрт ирүүлсэн хавсралт баримт бичгүүдийн иж бүрдэл, тэдгээрийн чанар, хугацаа зэрэг хүчин зүйлийг хамруулж үнэлсэн. Мөн үнэлгээний хүрээнд оролцогч багуулаас мэдлэг, ур чадварыг үнэлэх цахим тестийн үр дүнг үнэлгээний нэг бүлэгт тооцсон.

Үнэлгээг тайлагналын багийн зөвлөхүүд боловсруулж, Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн удирдлага, мэргэжилтнүүдэд танилцуулж, баталгаажуулсан.

Нийт 20 багийг 4 бүлэг шалгуур үзүүлэлтээр үнэлж, эрэмбэлэв. Нийт 112 (+2) оноо авах боломжтойгоос Булган, Архангай, Хэнтий аймгууд хамгийн өндөр оноогоор эрэмбэлэгдсэн.

¹⁰Төсвийн тухай хууль. 8 дугаар зүйл.Төсвийн цаглабар 8.9.5.төсвийн ерөнхийлөн захирагч хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 4 дүгээр сарын 05-ны дотор төрийн аудитын төв байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 25-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

Аймгийн нэр	Үр дүнд суурилсан нөөцийн удирдлага	Стратегийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ	Дотоод үйл ажиллагаа эрх зүйн баримт бичгийн хэрэгжилт	Хүний нөөцийн удирдлага, мэдлэг ур чадвар	Нийт	Эрэмбэ
Булган	32.00	46.00	9.00	2.00	89.00	I
Архангай	32.00	40.00	10.00	1.00	83.00	II
Хэнтий	28.00	42.00	10.00	1.00	81.00	III
Дундговь	20.00	46.00	10.00	1.00	77.00	IV
Говьсүмбэр	20.00	40.00	11.00	4.00	75.00	V
Дархан-Уул	24.00	40.00	7.00	1.00	72.00	VI
Сүхбаатар	20.00	36.00	10.00	4.00	70.00	VII
Увс	24.00	40.00	3.00	1.00	68.00	VIII
Хөвсгөл	20.00	40.00	4.00	1.00	65.00	IX
Өвөрхангай	20.00	34.00	9.00	-	63.00	X
Сэлэнгэ	24.00	32.00	4.00	1.00	61.00	XI
Баян-Өлгий	24.00	32.00	3.00	-	59.00	XII
Баянхонгор	16.00	32.00	3.00	1.00	52.00	XIII
Орхон	16.00	32.00	4.00	-	52.00	XIV
Ховд	16.00	30.00	3.00	1.00	50.00	XV
Нийслэл	16.00	26.00	4.00	2.00	48.00	XVI
Дорнод	20.00	24.00	3.00	-	47.00	XVII
Говь-Алтай	16.00	24.00	3.00	-	43.00	XVIII
Өмнөговь	8.00	26.00	4.00	1.00	39.00	XIX
Завхан	12.00	12.00	3.00	-	27.00	XX

Нийт 20 багийг 4 бүлэг шалгуур үзүүлэлтээр үнэлж, эрэмбэлэв. Нийт 112 (+2) оноо авах боломжтойгоос Булган аймаг 89 оноогоор үнэлэгдэж 1-т эрэмбэлэгдсэн бол Завхан аймгийн хувьд 27 оноогоор үнэлэгдэж 20-т эрэмбэлэгдсэн.

I. ҮР ДҮНД СУУРИЛСАН НӨӨЦИЙН УДИРДЛАГА

Аймгийн нэр	Бүлгийн дүн
Архангай	32
Булган	32
Хэнтий	28
Баян-Өлгий	24
Сэлэнгэ	24
Увс	24
Дархан-Уул	24
Дорнод	20
Дундговь	20
Өвөрхангай	20
Сүхбаатар	20
Хөвсгөл	20
Говьсүмбэр	20
Баянхонгор	16
Говь-Алтай	16

Ховд	16	Тус үнэлгээний хэсэг нь багууд буюу төсвийн ерөнхийлөн захирагчийн багцийн хүрээнд төсвийн эх үүсвэрийн төлөвлөлт, хэрэгжилт, түүний үр дүнгийн үнэлгээгээр дамжуулан үр дүнд суурилсан нөөцийн удирдлагыг үнэлсэн.
Нийслэл	16	
Орхон	16	
Завхан	12	
Өмнөговь	8	

Нийт 3 шалгуур үзүүлэлтээр үнэлсэн ба үр дүнд суурилсан нөөцийн удирдлагын бүлэг нь нийт үнэлгээний 40 хувийг илэрхийлэх өндөр ач холбогдолтой үнэлгээний бүрэлдэхүүн юм.

Тус бүлэгт багууд нийт 48 оноо авах боломжтой бөгөөд хамгийн өндөр буюу 32 оноо авсан баг нь үнэлгээний 67 хувийг хангаж байна.

Нөөцийн удирдлагын хувьд төсвийн болон хүрсэн түвшний биелэлтийг өндөр хангах нь чухал бөгөөд энэхүү хоёр зүгээрлэлтийн хувь нийт дүнд нөлөөлсөн. Өөрөөр хэлбэл төсвийн болон хүрсэн түвшний гүйцэтгэлийн хувь өндөр аймгууд өндөр оноогоор үнэлэгдсэн.

Тайлангийн иж бүрдэл дутуу, хүрсэн түвшний үр дүнг баталгаажуулах баримт бичиг ирүүлээгүй байдлыг үнэлгээнд харгалзсан.

Аймгийн нэр	Эх сурвалж Сангийн яам		ТЕЗ-ийн ирүүлсэн тайлан		Зөрүү		Гүйцэтгэлийн хувь	Авсан оноо
	Төсөв	Гүйцэтгэл	Төсөв	Гүйцэтгэл	Төсөв	Гүйцэтгэл		
Сэлэнгэ	59,946.8	42,424.3	59,946.8	42,554.9	-	130.6	86%	3
Баян-Өлгий	36,096.7	28,042.2	36,096.7	28,042.2	-	0.0	84%	3
Завхан	58,484.8	35,903.9	61,549.7	42,061.1	3,064.8	6,157.2	81%	3
Булган	50,829.5	35,679.4	52,058.7	36,755.5	1,229.2	1,076.2	81%	3
Увс	40,915.7	29,706.3	56,189.0	43,574.6	15,273.3	13,868.3	80%	3
Дундговь	46,262.6	23,835.4	46,262.6	23,835.4	-	0.0	77%	2
Хэнтий	57,466.6	39,869.1	100,223.7	39,846.3	42,757.1	(22.8)	76%	2
Дорнод	58,380.8	32,484.1	57,310.7	31,922.1	(1,070.1)	(562.0)	75%	2
Ховд	60,808.5	39,025.4	60,808.5	39,025.4	-	-	74%	2
Говь-Алтай	46,613.1	33,139.3	46,613.1	33,139.3	-	-	74%	2
Нийслэл	2,570,979.0	1,234,962.9	2,570,979.0	1,234,962.9	0.0	(0.0)	71%	2
Архангай	47,697.6	28,120.2	47,697.6	28,120.1	-	(0.1)	70%	2
Сүхбаатар	55,525.7	27,484.0	55,525.7	27,484.0	-	(0.0)	69%	1
Өвөрхангай	54,289.7	36,702.8	55,253.1	36,702.8	963.5	(0.0)	69%	1

Орхон	242,367.9	119,717.5	243,424.9	119,839.7	1,057.1	122.2	65%	1
Говьсүмбэр	19,519.6	11,271.2	19,519.6	11,271.2	-	(0.0)	65%	1
Дархан-Уул	51,279.4	29,253.6	51,279.4	29,253.6	(0.0)	(0.0)	61%	1
Өмнөговь	840,287.0	539,106.5	838,171.6	537,654.6	(2,115.3)	(1,451.9)	60%	1
Баянхонгор	56,374.3	41,309.1	15,139.9	7,888.3	(41,234.4)	(33,420.7)	52%	1
Хөвсгөл	56,052.6	39,144.7	53,844.4	35,903.1	2,208.1)	3,241.6)	41%	1

I.1. Төсвийн гүйцэтгэлийн хувь

Төсвийн нөөцийн бодитой зөв хуваарилж, зарцуулах нь чухал. Иймд үр ашигтай уялдуулсан шалгуураас энэ шалгуур нь ялгаатай бөгөөд зөвхөн батлагдсан төсвөө үр дүнтэй зарцуулалтыг зохион байгуулж чадсан эсэхийг үнэлэв.

Дэмжих хөтөлбөрт оролцсон 20 төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд 4.5 тэрбум төгрөгийн төсвийн гүйцэтгэлийг тайлагнасан бөгөөд нийт дундаж гүйцэтгэл 54 хувь буюу 2.4 тэрбум төгрөг байна. Төсвийн гүйцэтгэл нь аймаг бүрт харилцан адилгүй ба 41-86 хувийн хооронд хэлбэлзэж байгаа бөгөөд аймгуудын гүйцэтгэлийн жигнэсэн дундаж 71 хувьтай байна.

Төсөв, гүйцэтгэлийн мэдээллийг баталаажсан тайлангийн төсөв гүйцэтгэлээс зөрүүтэй тайлагнах, нэгжийг мянган төгрөгөөр тайлагнах ёстой боловч төгрөгөөр, сая төгрөгөөр ялгаатай тайлагнах, хөтөлбөр тус бүрээр төсвийг ангилаагүй зэрэг техник алдаа гарч байсан бөгөөд тухай бүрд засварлаж хүлээж авсан.

Төсвийн гүйцэтгэлийн үнэлээг хөтөлбөр тус бүрийн төсвийн гүйцэтгэлийн жигнэсэн дундаж хувиар дүгнэж, аргачлалын дагуу харгалзах оноогоор үнэлсэн.

I.2. Хүрсэн түвшний гүйцэтгэлийн хувь

Ерөнхий үнэлгээний нормын дагуу гүйцэтгэлийн хувьд харгалзуулан оноогоор үнэлсэн. Дэмжих хөтөлбөрт оролцсон 20 төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд аймаг бүрт харилцан адилгүй ба 58-101 хувийн хооронд хэлбэлзэж байгаа бөгөөд аймгуудын гүйцэтгэлийн жигнэсэн дундаж 87 хувьтай байна.

Аймгийн нэр	Хүрсэн түвшний хувь	Суурь оноо	Баталгаажуулахад харгалзсан оноо	Авсан оноо
Архангай	104%	4.00		4.00
Булган	88%	3.00		3.00
Хөвсгөл	101%	4.00	(1.00)	3.00
Хэнтий	89%	3.00		3.00

Дархан-Уул	87%	3.00		3.00
Баян-Өлгий	96%	3.00	(1.00)	2.00
Баянхонгор	100%	3.00	(1.00)	2.00
Дорнод	87%	3.00	(1.00)	2.00
Дундговь	79%	2.00		2.00
Өвөрхангай	80%	2.00		2.00
Сүхбаатар	84%	2.00		2.00
Сэлэнгэ	92%	3.00	(1.00)	2.00
Увс	96%	3.00	(1.00)	2.00
Ховд	86%	3.00	(1.00)	2.00
Орхон	86%	3.00	(1.00)	2.00
Говьсүмбэр	84%	2.00		2.00
Говь-Алтай	77%	2.00	(1.00)	1.00
Өмнөговь	80%	2.00	(1.00)	1.00
Нийслэл	70%	2.00	(1.00)	1.00
Завхан	58%	1.00	(1.00)	-

Хүрсэн түвшний үзүүлэлт аймгуудад харьцангуй өндөр тайлагнаж байгаа нь хүрсэн түвшний шалгуур үзүүлэлтийн хувьд олон үзүүлэлт хагас жилээр илэрхийлэгдэх боломжгүйгээс шалтгаалан өмнөх оны түвшинд эсхүл хүлээгдэж буй мэдээллээр үнэлэгдэж байгаатай мөн холбоотой байна. Иймд үнэлгээг хийхдээ тухайн үр дүн нь тайлан мэдээгээр батлгаажиг ирсэн эсэхийг харгалзан үзсэн бөгөөд ямар нэг тайлан, нотлох баримт бичиг ирүүлээгүй, тайланг албан ёсоор баталгаажуулагүй тохиолдолд оноог бууруулан тооцсон.

I.3. Төсөв, үр ашгийн уялдаа

Тус шалгуурыг төсвийн зарцуулалт болон хөтөлбөрийн үр ашиг хоёрын уялдааг харгалзах зорилгоор хоёр үзүүлэлтийг харгалзан үнэлэв. Хувь хэмжээнд Сангийн сайдын 2023 оны 225 тоот тушаалд заасан хувь хэмжээг ашиглав.

Аймгийн нэр	Суурь оноо	Баталгаажуулалтад харгалзсан оноо	Авсан оноо
Архангай	2		2.00
Булган	2		2.00
Өвөрхангай	2		2.00
Сүхбаатар	2		2.00
Хэнтий	2		2.00
Дархан-Уул	2		2.00
Говьсүмбэр	2		2.00
Баян-Өлгий	2	(1.00)	1.00
Баянхонгор	2	(1.00)	1.00

Говь-Алтай	2	(1.00)	1.00
Дорнод	2	(1.00)	1.00
Дундговь	1		1.00
Сэлэнгэ	2	(1.00)	1.00
Увс	2	(1.00)	1.00
Хөвсгөл	2	(1.00)	1.00
Нийслэл	2	(1.00)	1.00
Орхон	2	(1.00)	1.00
Завхан	1	(1.00)	-
Өмнөговь	1	(1.00)	-
Ховд	1	(1.00)	-

Тус үнэлгээний хувьд төсөв бүрэн зарцуулсан аймаг байхгүй тул тохиолдолд 1-2 оно авах болмжтой бөгөөд үр ашигтай аймаг 2, үр ашиггүй аймаг 1 оноотой үнэлэгдсэн. Мөн үнэлгээг хийхдээ тухайн үр дүн нь тайлан мэдээгээр

батлгаажиг ирсэн эсэхийг харгалзан үзсэн бөгөөд ямар нэг тайлан, нотлох баримт бичиг ирүүлээгүй, тайланг албан ёсоор баталгаажуулагүй тохиолдолд оноог бууруулан тооцсон.

II. Стратегийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ

Аймгийн нэр	Бүлгийн дүн
Булган	46
Дундговь	46
Хэнтий	42
Архангай	40
Увс	40
Хөвсгөл	40
Дархан-Уул	40
Говьсүмбэр	40
Сүхбаатар	36
Өвөрхангай	34
Баян-Өлгий	32
Баянхонгор	32
Сэлэнгэ	32
Орхон	32
Өмнөговь	26
Нийслэл	26
Говь-Алтай	24
Дорнод	24
Ховд	14
Завхан	12

Тус үнэлгээний хэсэг нь багууд буюу төсвийн ерөнхийлөн захирагчийн багцийн хүрээнд төсвийг үр дүнтэй уялдуулан төлөвлөж, зарцуулсан бодлогын уялдааг үнэлэх зорилготой. Нийт 4 шалгуур үзүүлэлтээр үнэлсэн ба стратегийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээний удирдлагын бүлэг нь нийт үнэлгээний 40 хувийг илэрхийлэх өндөр ач холбогдолтой үнэлгээний бүрэлдэхүүн юм.

Тус бүлэгт багууд нийт 50 оноо авах боломжтой бөгөөд хамгийн өндөр буюу 46 оноо авсан баг нь үнэлгээний 92 хувийг хангаж байна.

Стратегийн удирдлагын хувьд хөтөлбөрийн нэгдсэн үнэлгээний болон түүний үр ашиг, тэдгээр үр ашгийг үнэн

бодитой, баталгаатай эх сурвалжаар бэлтгэсэн эсэх нь чухал үзүүлэлт болж байна. Мөн тухайн хөтөлбөр нь төсвөө зарцуулаагүй, үр ашггүй илэрхийлэгдсэн нь бодитой шалтгаан нөхцөл үүссэн эсэхийг тайлбарлаж нотолож байгаа эсэхийг тооцсон.

Тайлангийн иж бүрдэл дутуу, хүрсэн түвшний үр дүнг баталгаажуулах баримт бичиг ирүүлээгүй байдлыг үнэлгээнд харгалзсан.

II.1. Мэдээллийн албан ёсны эх сурвалж

Аймгийн нэр	Авсан оноо
Булган	4
Дундговь	4
Увс	4
Хөвсгөл	4
Говьсүмбэр	4
Архангай	3
Сүхбаатар	3
Хэнтий	3
Дархан-Уул	3
Баян-Өлгий	2
Завхан	2
Өвөрхангай	2
Өмнөговь	2
Сэлэнгэ	2
Ховд	2
Орхон	2
Баянхонгор	1
Говь-Алтай	1
Дорнод	1
Нийслэл	1

Баталгаажуулсан эх сурвалжид үндэслэн үнэлэв. Хөтөлбөр арга хэмжээний тайлагналын хувьд төсвийн тоон мэдээллээс бусад үзүүлэлт нь нэмэлт эх суравжл болох албан ёсны статистик мэдээ, аймгийн болон байгууллага, газар хэлтсийн албан тайлан мэдээ зэрэг эх сурвалжаар баталгаажих зайлшгүй шаардалага үүсдэг. Нөгөө талаар тухайн эх сурвалжийг зөв сонгох, хэрэглэх зэрэг нь тайлангийн үр дүнд шууд нөлөөлж байна.

Иймд тус дэмжих хөтөлбөрийн хүрээнд оролцогчдыг эх сурвалжийн хэрэглээ, түүнийг ашиглан баталгаажуулж байгаа эсэх цаашдаа үүнийг хэрэгжлэх ур чадвар суулгах зорилгоор үнэлгээнд тус үзүүлэлтийг оруулсан. Мөн Сангийн сайдын 2023 оны 225 тушаалаар баталсан аргачлалд эх сурвалжаар

баталгаажсан байх шаардлагыг оруулсан.

Иймд тус үнэлээнд аймгууд ямар төрлийн баримт бичгийг эх сурвалжаар ашиглаж байгаад харгалуулан оноо өгч үнэлсэн бөгөөд статистик мэдээнээс эхлэн ач холбогдлын дагуу оноог харгалзуулан дүгнэсэн.

II.2. Хөтөлбөрийн гүйцэтгэл

Ерөнхий үнэлгээний нормын дагуу гүйцэтгэлийн хувьд харгалзуулан оноогоор үнэлэв.

Аймгийн нэр	Хөтөлбөрийн гүйцэтгэл	Суурь оноо	Баталгаажуулалтад харгалзсан оноо	Авсан оноо
Архангай	91%	3		3
Баянхонгор	100%	4	-1	3
Булган	95%	3		3
Дундговь	93%	3		3
Хэнтий	89%	3		3
Дархан-Уул	70%	3		3
Баян-Өлгий	94%	3	-1	2
Өвөрхангай	81%	2		2
Өмнөговь	85%	3	-1	2
Сүхбаатар	82%	2		2

Сэлэнгэ	91%	3	-1	2
Увс	84%	3	-1	2
Хөвсгөл	89%	3	-1	2
Орхон	84%	3	-1	2
Говьсүмбэр	84%	2		2
Говь-Алтай	81%	2	-1	1
Дорнод	81%	2	-1	1
Ховд	99%	2	-1	1
Нийслэл	86%	2	-1	1
Завхан	58%	1	-1	0

Хөтөлбөрийн гүйцэтгэлийг маягтын дагуу ирүүлсэн үнэлгээнд харгалзан үнэлсэн ба аймгуудын

хувьд хөтөлбөр, үр ашгийн үзүүлэлт дээр техникийн алдаа, тооцоолол буруу байх нь түгээмэл байсан. Ийм төрлийн алдаа зөрчлийг үнэлгээнд харгалзаагүй бөгөөд зөвхөн аймгийн хэмжээний хөтөлбөрийн жигнэсэн дундаж хөтөлбөрийн гүйцэтгэлийн хувийг суурь оноогоор үнэлсэн.

Баталгаажуулсан эх сурвалжид үндэслэн үнэлэв.

II.3. Үр ашиг

Аймгийн нэр	Үр ашиг	Суурь оноо	Баталгаажуулалтад харгалзсан оноо	Авсан оноо
Архангай	41%	4		4
Булган	14%	4		4
Дундговь	15%	4		4
Өвөрхангай	1%	4		4
Сүхбаатар	16%	4		4
Хэнтий	15%	4		4
Дархан-Уул	10%	4		4
Говьсүмбэр	23%	4		4
Баян-Өлгий	11%	4	-1	3
Баянхонгор	48%	4	-1	3
Говь-Алтай	7%	4	-1	3
Дорнод	6%	4	-1	3
Сэлэнгэ	11%	4	-1	3
Увс	-2%	4	-1	3
Хөвсгөл	51%	4	-1	3
Нийслэл	15%	4	-1	3
Орхон	23%	4	-1	3
Өмнөговь	-2%	2	-1	1
Завхан	-			
	23%	1	-1	0
Ховд	28%		-1	-1

Хөтөлбөрийн үр ашгийн үзүүлэлтийг техник алдаа, тооцооллыг засварласны дараах эцсийн байдлаар аймгийн хэмжээний нэгдсэн дундаж үр ашгийн хувьд харгалзуулан аргачлалын дагуух 1-4 оноогоор үнэлсэн. Үр ашгийн хувьд 3 аймаг үр ашиггүй, 17 аймаг эерэг буюу дунджаар үр ашигтай илэрхийлэгдсэн. Гэвч

эдгээр үзүүлэлт нь зөвхөн маягтаар илэрхийлэгдсэн тул үр дүнг баталгаажуулах эх сурвалжид мөн тулгуурласан. Тайлангийн иж бүрдэл дутуу, хүрсэн түвшний үр дүнг баталгаажуулах баримт бичиг ирүүлээгүй байдлыг үнэлгээнд харгалзсан.

II.4. Гүйцэтгэлийн хувь зорилтот түвшиндээ хүрээгүй бол тайлбар үндэслэлтэй эсэх

Хөтөлбөр, арга хэмжээний тайланд төсвийн хэрэгжилт хангалтгүй, төсвийн гүйцэтгэл гараагүй тохиолдолд үндэслэлтэй тайлбар нотолгоог ирүүлэхийг Сангийн сайдын 225 дугаар тушаалаар баталсан зааварт заасны дагуу тус хэсгийг үнэлгээнд харгалзан үзсэн. Үүнд Бодлогын баримт бичигт, хөгжлийн төлөвлөгөөнд өөрчлөлт орсон эсэх, Улсын төсвийн нэмэлт өөрчлөлттэй уялдаж төсөвт өөрчлөлт орсон эсэх гэсэн дээрх хүндэтгэн үзэх нөлөөллөөс төсвийн гүйцэтгэл бага гарсныг нотолсон тайлбар баримттай эсэхийг анхаарсан. Эхний хагас жилийн тайланд нийт дараах 7 аймаг мэдээллэл тайлбарыг ирүүлсэн тул тус шалгуур үзүүлэлтэд харгалзах 2 оноог нэмэгдүүлэн тооцсон.

1. Булган
2. Дундговь
3. Өвөрхангай
4. Өмнөговь
5. Ховд
6. Хэнтий
7. Нийслэл

III. Дотоод үйл ажиллагаа эрх зүйн баримт бичгийн хэрэгжилт

Тус үнэлгээний хэсэг нь багууд буюу төсвийн ерөнхийлөн захирагчийн багцийн хүрээнд хөтөлбөр, арга хэмжээний тайланг боловсруулах, нэгтгэх, баталгаажуулах үйл ажиллагааг хэрхэн гүйцэтгэснийг үнэлсэн.

Аймгийн нэр	Бүлгийн дүн
Архангай	10
Дундговь	10
Хэнтий	10
Говьсүмбэр	11
Булган	9
Өвөрхангай	9
Сүхбаатар	10
Дархан-Уул	7
Өмнөговь	4
Сэлэнгэ	4
Хөвсгөл	4
Нийслэл	4
Орхон	4
Баян-Өлгий	3
Баянхонгор	3
Говь-Алтай	3
Дорнод	3

Завхан	3
Увс	3
Ховд	3

Энэ нь дотоод үйл ажиллагааны үр дүн, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг хэрхэн хангаж байгааг илэрхийлэх юм.

Тус бүлэгт багууд нийт 12 оноо авах боломжтой бөгөөд аймгууд 3-10 хүртэлх оноогоор үнэлэгдсэн. Энэ нь бичиг баримт, баталгаажуулалт, хугацааны шаардлагыг бүрэн хангасан аймаг байхгүйг харуулж байгаа бөгөөд цаашид хөтөлбөр, арга хэмжээний тайланг төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлангийн иж бүрдэл, хугацааны нэгэн адил ач холбогдол өгч бүрэлдэхүүн тайланг боловсруулдаг дадал хэвшил бий болгох шаардлагатайг харуулж байна.

Ш.1. Журмын батлагдсан маягт, иж бүрдэл, албан бичгийн стандартын дагуу бэлтгэгдсэн эсэх, хавсралтаар тогтоол ирсэн эсэх

Аймгийн нэр	Гарын үсэгтэй маягт ирүүлсэн эсэх	Баталгаажуулах тайлан төлөвлөгөөний биелэлт ирүүлсэн эсэх	Аймгийн тогтоол	Авса оноо
Архангай	+	+	+	4
Дундговь	+	+	+	4
Сүхбаатар	+	+	+	4
Хэнтий	+	+		4
Дархан-Уул		+	+	4
Говьсүмбэр	+	+	+	4
Булган	+		+	3
Өвөрхангай	+		+	3
Нийслэл			+	2
Баян-Өлгий				1
Баянхонгор				1
Говь-Алтай				1
Дорнод				1
Завхан				1
Өмнөговь				1
Сэлэнгэ				1
Увс				1
Ховд				1
Хөвсгөл				1
Орхон				1

Хөтөлбөр, арга хэмжээний тайлангийн биелэлт нь баталгаажуулалт, нотлох эх сурвалжтай шууд холбоотой тул үнэлгээний тус хэсэгт иж бүрдлийг хэрхэн хангасанд харгалзуулан үнэлсэн. Аймгуудын хувьд баталгаажуулалт, иж бүрдэл 12 аймгийн хувьд эхсэл маягтаас өөр мэдээлэл тайлан нэггэх хугацаанд ирүүлээгүй байгаа нь орон нутагт хөтөлбөр, арга хэмжээний тайланд ач холбогдол өгөхгүй, зохион байгуулалтыг муу хийж, мэдээлэл солилцох үйл ажиллагаа дутагдалтай байгааг харуулж байна. Түүнчлэн хагас жилийн тайлан 8 сард төрийн албан хаагчдын ээлжийн амралтын хугацаатай давхцаж байгаа нь ттайлангийн чанарт нөлөөлж байна.

III.2. Хугацаандаа ирүүлсэн эсэх

Аймгийн нэр	Хугацаа	Авсан оноо
Архангай	8/15/2024	2.00
Булган	8/15/2024	2.00
Дундговь	8/15/2024	2.00
Өвөрхангай	8/15/2024	2.00
Өмнөговь	8/15/2024	2.00
Сүхбаатар	8/15/2024	2.00
Сэлэнгэ	8/15/2024	2.00
Хөвсгөл	8/15/2024	2.00
Хэнтий	8/15/2024	2.00
Дархан-Уул	8/15/2024	2.00
Орхон	8/15/2024	2.00
Говьсүмбэр	8/15/2024	3.00
Баян-Өлгий	8/21/2024	1.00
Баянхонгор	8/20/2024	1.00
Говь-Алтай	8/27/2024	1.00
Дорнод	8/21/2024	1.00
Завхан	8/27/2024	1.00
Увс	8/27/2024	1.00
Ховд	8/28/2024	1.00
Нийслэл	8/21/2024	1.00

Тайланг хуулийн хугацаанд ирүүлэх нь чухал үзүүлэлтийн нэг бөгөөд цаашид улсын хэмжээнд иж бүрдэл, хугацаа баримталж ажиллахыг хэвшүүлэхийг зорьж байна. Иймд үнэлгээнд хугацааг тусгайлсан шалгуур үзүүлэлт болсон. Хуулийн хугацаа нь хамгийн сүүлийн хугацаа учраас хугацаанаас өмнө ирүүлж аливаа засваргүй тайлан боловсруулж дууссан тохиолдолд хамгийн өндөр буюу 3-4 оноогоор үнэлэхээр аргачлал оловсруулсан боловч хугацаанаасаа өмнө дуусгасан аймаг дуусгасан аймаг байхгүй.

Иймд зааварт заасан хугацаандаа ирүүлэн аймаг 2 оноо, хугацаа хоцроож ирүүлсэн аймагт 1 оноо өгсөн. Нийт аймгийн 12 нь буюу 60 хувь нь хугацаандаа ирүүлсэн. Хугацаа хоцроосон аймгуудын хувьд хэдэн хоногоор хоцроосноос үл хамааран 1 хоногоор үнэлсэн ба хамгийн сүүлийн аймаг 8 дугаар сарын 28-ны өдөр ирүүлж байгаа нь цаашид тайлан мэдээг хугацаанд ирүүлж хэвших дотоод үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх

шаардлага буйг харуулж байна.

III.3. Тайлангийн хяналтын хэсгийн иж бүрдэл хангасан эсэх

Аймгийн нэр	Гарын үсэгтэй маягт ирүүлсэн эсэх	Гарын үсгийн тоо	Гарын үсгийн тоо
Архангай	+	3	4
Булган	+	4	4
Дундговь	+	4	4
Өвөрхангай	+	4	4
Хэнтий	+	ЗД албан бичигтэй	4
Говьсүмбэр	+	3	4
Сүхбаатар	+	1	4
Баян-Өлгий			1
Баянхонгор			1
Говь-Алтай			1
Дорнод			1
Завхан			1
Өмнөговь			1
Сэлэнгэ			1
Увс			1
Ховд			1
Хөвсгөл			1
Дархан-Уул			1

Нийслэл			1
Орхон			1

Сангийн сайдын 2023 оны 225 дугаар

тушаалаар баталсан зааврын дагуу “Хяналт” хэсэгт (1) төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиг үүрэг, (2) бодлого, стратегийн чиг үүрэг, (3) дотоод хяналт, хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан чиг үүрэг бүхий нэгж, албан хаагч хөтөлбөр, арга хэмжээний тайланг баталгаажуулан ирүүлэхээр тусгайлан тусгасан байдаг.

Үүнийг дэмжих хөтөлбөрийн үнэлгээнд тусгайлан шалгуур үзүүлэлт болгож үнэлсэн бөгөөд 6 аймаг баталгаажуулалтыг иж бүрэн ирүүлсэн ба үүний нэг нь төсвийн ерөнхийлөн захирагчийн албан бичгээр баталгаажин ирсэн тул тооцож 4 оноогоор үнэлсэн.

Зөвхөн нэг нэгжийн баталгаажуулсан аймгийг 2 оноогоор үнэлсэн бөгөөд баталгаажуулалт хийгээгүй, маягтыг цахимаар ирүүлсэн аймгуудыг доод оноо буюу 1 оноогоор тус тус үнэлсэн.

Цаашид баталгаажуулалтын үйл ажиллагааг хэвшүүлж, аймаг дотоод үйл ажиллагааны уялдаа холбоо, тайланг боловсруулах үр дүнг сайжруулах шаардлагатай байна.

IV. Мэдлэг ур чадварын тест

Аймгийн нэр	Багийн гишүүдийн тоо	Тест өгсөн хүний тоо	Тестийн нийт оноо	Тестийн дундаж оноо	Авсан оноо
Сүхбаатар	7	6	48	10	4
Говьсүмбэр	7	6	49	10	4
Булган	7	5	35	7	2
Нийслэл	6	5	35	7	2
Архангай	7	4	26	5	1
Баянхонгор	7	4	25	5	1
Дундговь	7	5	18	4	1
Өмнөговь	7	2	13	3	1
Сэлэнгэ	7	3	9	2	1
Увс	7	3	13	3	1
Ховд	5	2	10	2	1
Хөвсгөл	7	3	19	4	1
Хэнтий	7	5	24	5	1
Дархан-Уул	5	3	19	4	1
Баян-Өлгий	7			-	
Говь-Алтай	5			-	
Дорнод	7			-	
Завхан	8			-	
Өвөрхангай	7			-	
Орхон	7			-	

Мэдлэг ур чадварын тестийг 10 асуулт бүхий цахим формоор боловсруулан 2024 оны 7 дугаар сарын 25 өдөр 16 цагт зохион байгуулсан.

Нийт асуултыг зөвхөн Сангийн сайдын 2023 оны 225 дугаар тушаалаар баталсан зааврын хүрээнд бэлтгэсэн.

Нэг асуултад 1 минутаар тооцсон нийт 10 минутын хугацаанд тестийг улсын хэмжээнд нэгэн зэрэг зохион байгуулсан бөгөөд урьдчилан 2 удаа багуудад мэдээлэл, цагийг хүргүүлсэн байсан.

Тестийг тухайн цаг хугацаанд оролцох боломжтой багийн гишүүд хамрагдсан. Нийт 20 багийн 134 оролцогч байснаас 14 багийн 56 оролцогч тестийг хийсэн.

Тестэнд авах боломжтой хамгийн өндөр оноо нь 10 оноо боловч 5 оролцогч хамгийн өндөр буюу 9 оноо авсан.

Багуудын идэвх харилцан адилгүй байсан бөгөөд Говьсүмбэр, Сүхбаатар аймгууд 7 гишүүдээс 6 нь тест өгч идэвх 86 хувьтай байсан 6 аймаг нэг ч гишүүн оролцоогүй

Багудын нийт гишүүдийн тоо харилцан адилгүй байгаа учраас тэгш зарчмын үүднээс багийн дундаж оноог 5 гишүүний дундажаар тооцож, харгалзах оноогоор үнэлсэн.

Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнгийн тайлан нэгтгэхэд гарч буй алдаа, цаашид анхаарах асуудал:

Орон нутгийн ТЕЗ-ийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн тайланд цаашид сайжруулах шаардлагатай дараах нийтлэг алдаанууд байна.

1. Хөтөлбөрийн нэр, хөтөлбөрийн хүрэх үр дүнг ижил тодорхойлж баталсан.
2. Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүнд төсөл арга хэмжээний тоог бичих.
3. “Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байх”, “Санхүүжилт хийсэн байх”, “Хууль тогтоомжид нийцсэн байх” гэх мэт ерөнхий, хүрэх үр дүн тодорхойгүй байдлаар томъёолох.
4. Хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүн уялдаагүй байх. Жишээлбэл: “Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх” хөтөлбөрийн хүрэх үр дүн “Төсөл арга хэмжээг бүрэн санхүүжүүлэх”, “Цагдаа” хөтөлбөрийн хүрэх үр дүн нь “Нийтийн тээврийн үйлчилгээг хянах” гэх мэт.
5. Хөтөлбөрийг хэт ерөнхий байдлаар томъёолсноос шалтгаалсан нэг хөтөлбөрийн хүрэх үр дүн хэт олон байх.
6. Орон нутагт төрийн байгууллага, албан хаагчдын ажлын уялдаа болон тогтвортой байдалтай шууд холбоотой бөгөөд Төсөв санхүү, бодлого төлөвлөлт, хяналт шинжилгээний албан хаагчдын ажлын уялдаа холбоо сул, хүрсэн үр дүнгийн мэдээллийг маягтын дагуу гарын үсгийн иж бүрэн байдлыг хангаж ирүүлээгүй.
7. Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв хүрсэн үр дүнгийн тайланг хэрхэн тайлагнах тухай заавар, аргачлалыг уншиж судлаагүй. (Сангийн сайдын 2023 оны 255 дугаар тушаал)
8. Аймгийн ИТХ-ын тогтоолын 1 дүгээр хавсралт буюу хүрэх үр дүнгийн хавсралт хяналт, оролцоо сул байгаагаас хөтөлбөр, түүний хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийн боловсруулалт хангалтгүй.

Санал, дүгнэлт

1. Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч нарын хөтөлбөр, шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийг гаргахад ашиглах эх сурвалж, тоон мэдээлэл тодорхойгүй, хариуцах албан хаагч, байгууллага ойлгомжгүй байх зэрэг нь хугацаа алдах, удаашрах шалтгаан болж байсан. Үүнд хөтөлбөр, арга хэмжээний тайлан нь тодорхой эрх зүйн баримт бичгээр баталгаажсан маягтын дагуу хоёр дахь удаа тайлагнаж байгаа нь нөлөөлсөн бөгөөд цаашид журмын дагуу төлөвлөж, тайлагнаж хэвшсэнээр сайжрах боломжтой.

2. Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч нарт хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлоогүй ихэвчлэн арга хэмжээний түвшинд шалгуур үзүүлэлтийг баталсан байна. Өөрөөр хэлбэр тухайн хөтөлбөр хэрэгжүүлээд гарах үр дүн бус төсвийг зарцуулсан байгууллагын үйл ажиллагааны явцаар хүрэх түвшинг төлөвлөсөн нь эргээд тайлагнахад тухайн хөтөлбөрийн үр ашгийг бүрэн тодорхойлох боломжгүйд хүргэж байсан. Жишээ 1 нь: Үйл ажиллагаагаар: “Иргэдийн төлөөлөгчдийн хурлыг 5 удаа зохион байгуулах”. Жишээ 2: Шалгуур үзүүлэлтийг хэмжигдэхүйц биш ихэвчлэн өгүүлбэрээр баталсан. “Орон нутгийн гүйцэтгэх засаглалын байгууллагын үйл ажиллагааны хэвийн, жигд байдал хангагдсан”. Жишээ 3. нийтлэг төсвийн ерөнхийлөн захирагч нар дээр зорилтын хэрэгжилтийг хангах, тэд- ээс доошгүй гэх мэт шалгуур үзүүлэлт баталсан нь гүйцэтгэл, үр дүн тооцоход хүндрэлтэй байсан. “Хурлын хуралдааныг улиралд 1-с доошгүй, удаа хуралдуулж шийдвэр гаргана гэх мэт.”

3. Цаашид төлөвлөлт, төсөвлөлтийн бүх үе шатанд үр дүнд суурилсан төлөвлөлтийн зарчим, шалгуур үзүүлэлтэд тавигдах шаардлага, хөтөлбөр, арга хэмжээний тайлангийн холбогдох журамд заасан шалгуур, эх сурвалжийн баталгаажуулалт зэргийг сайжруулснаар тайлагналын явцын болон эцсийн үр дүн бодитой, найдвартай, хэмжигдэхүйц, шуурхай болох боломжтой.

4. Аймгийн ИТХ-ын тогтоолын 1 дүгээр хавсралт буюу хүрэх үр дүнгийн хавсралт хяналт, оролцоо сул байгаагаас хөтөлбөр, түүний хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийн боловсруулалт хангалтгүй байна. Иймд хөтөлбөр, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт техникийн болон уялдааны хувьд олон ялгаатай байдлаар тогтоосон нь цаашид үр дүнг хэмжих, тайлагнах боломжийг хязгаарлаж байсан.

5. Иймд цаашид хөтөлбөрийн үр дүнг төлөвлөхдөө удирдамжийн зарчим, шаардлагыг хатуу мөрдөх, түүнийг хянаж шалгаж, нэгтгэх шаардлагатай байна.

ХАВСРАЛТ

Хавсралт № 1 Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн системд тусгасан 2024 оны хөтөлбөр, түүний үр дүн, шалгуур үзүүлэлт

Хөтөлбөрийн код	Хөтөлбөрийн нэр	Хөтөлбөрийн хүрэх үр дүн	Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Суурь он	Мэдээллийн албан ёсны эх сурвалж	Оролцооны хувь	Өгсөх, буурах
70101	Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагаа	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан үндэсний хөтөлбөр, чуулган, форум, уулзалт, хөтөлбөрт арга хэмжээ болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн төрийн айлчлал, бусад арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Хэрэгжилтийн биелэлт	хувь	2022	Улсын Их Хурлын Тамгын газрын жилийн үйл ажиллагааны тайлан	100.0%	Өгсөх
70102	Хууль тогтоох, хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих	Хууль тогтоомжийн төслийг Байнгын хорооны болон Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулна.	Хууль тогтоомжийн төсөл	тоо	2022	Улсын Их Хурлын Тамгын газрын жилийн үйл ажиллагааны тайлан	50.0%	Өгсөх
		Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үр дагаврын үнэлгээ хийж эрх зүйн орчныг сайжруулах нөхцөлийг бүрдүүлнэ.	Хяналтад авах хууль тогтоомж	тоо	2022	Улсын Их Хурлын Тамгын газрын жилийн үйл ажиллагааны тайлан	50.0%	Өгсөх
70103	Гүйцэтгэх засаглалын удирдлага	Хууль тогтоомж, хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангуулна.	Хууль болон журмын хугацаанд тайлагнах бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, төсөл, хөтөлбөр	тоо	2022	Үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлан	100.0%	Өгсөх

70104	Ерөнхийлөгч, хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалын удирдлагын судалгаа шинжилгээ	Үйл ажиллагааны хэрэгжилт	Хэрэгжилтийн биелэлт	хувь	2023	Холбогдох тайлан, дүгнэлт	100.0%	Өгсөх
70105	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	Иргэдийн төлөөлөгчидийн хурлын шийдвэр нь орон нутгийн хөгжлийг дэмжихэд чиглэнэ	Иргэдийн төлөөлөгчидийн шийдвэрийн хэрэгжилт	хувь	2022	Үйл ажиллагааны албан ёсны тайлан	50%	Өгсөх
		Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах хуулийг сурталчлах, иргэдийг мэдээллээр хангана	Үйл ажиллагааны хэрэгжилт	хувь	2022	Үйл ажиллагааны албан ёсны тайлан	50%	Өгсөх
70106	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.	Иргэдийн сэтгэл ханамж	хувь	2022	Иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа	50%	Өгсөх
	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	Улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтын үр дүнг хангах	Хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний тоо	тоо	2022	Хөрөнгө оруулалт, албан ёсны тайлан мэдээ	50%	Өгсөх
70201	Эдийн засгийн хөгжлийн төлөвлөлт	Хөтөлбөртэй байх шаардлагагүй. Зөвхөн ажлын албадын урсгал зардлууд тусч батлагддаг.	Шадар сайдын ажлын алба	хувь	2023	Байгууллагын үйл ажиллагааны тайлан	20.0%	Өгсөх
		Дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын хүрээг тодорхойлно	Бодлого, төлөвлөлтийн баримт бичиг	тоо	2022	Үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлан	20.0%	Өгсөх
		Гадаад худалдааг хөнгөвчилж, экспортын үйл ажиллагаанд зарцуулж байгаа хугацааг бууруулна.	экспортын үйл ажиллагаанд зарцуулж байгаа хугацаа	цаг	2022	Үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлан	20.0%	Буурах
		Гадаад худалдаа, экспорт хийх таатай нөхцөл, боломжийг бүрдүүлнэ.	Засгийн газар хооронд байгуулах хэлэлцээр	тоо	2022	Үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлан	20.0%	Өгсөх

		Бүс орон нутгийн хөгжлийг нэмэгдүүлнэ.	Орон нутгийн хөгжлийн индекс	оноо	2021	Үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлан	20.0%	Өгсөх
70202	Санхүү, төсвийн нэгдсэн удирдлага	Санхүү, төсвийн үйл ажиллагааг үр дүнтэй удирдлагаар хангана	Үйл ажиллагааны хэрэгжилт	хувь	2022	Холбогдох албан ёсны тайлан мэдээ	50%	Өгсөх
		Төсвийн ил тод байдлыг нэмэгдүүлнэ.	Олон улсын "Төсвийн нээлттэй байдал" үнэлгээ	оноо	2021	Сангий яам	50.0%	Өгсөх
70203	Засгийн газрын өрийн үйлчилгээ	Гадаад зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан дээлдүүлсэн зээлийн өрийг барагдуулна.	Өр барагдуулалтын хувь	хувь	2022	Холбогдох албан ёсны тайлан мэдээ	50%	Өгсөх
		Үйл ажиллагааны үр дүнг сайжруулна	Өрийн үйл ажиллагааны үр дүн	хувь	2023	Холбогдох тайлан, дүгнэлт	50.0%	Өгсөх
70204	Санхүүгийн зах зээлийн зохицуулалт	Зохицуулалтын хүрээний санхүүгийн салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгоно.	Хууль тогтоомжид нийцүүлэн шинээр боловсруулах журмын төсөл	тоо	2022	Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажилагааны тайлан	20.0%	Өгсөх
		Банкнаас бусад санхүүгийн салбарын эрсдэлийн үнэлгээг сайжруулах тогтолцоог бэхжүүлнэ.	Үнэт цаас, даатгал, бичил санхүүгийн салбарт эрсдэлд суурилсан хяналт, шалгалт хийх тоо	тоо	2022	Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажилагааны тайлан	20.0%	Өгсөх
		Санхүүгийн зах зээлийн судалгаа, шинжилгээг сайжруулна.	Эрдэм шинжилгээ, судалгааны тайлан	тоо	2022	Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажилагааны тайлан	20.0%	Өгсөх
		Зохицуулалттай салбараас оролцогчдын санхүүгийн боловсролыг дээшлүүлнэ.	Зохицуулалттай салбарын оролцогчид	тоо	2022	Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажилагааны тайлан	20.0%	Өгсөх
		Махны эрэлт нийлүүлэлтэд тохирсон бодлого зохицуулалтаар хангана.	Нөөцийн махны хэмжээ	тн	2023	Холбогдох албан ёсны тайлан мэдээ	20%	Өгсөх
70205	Татвар хураалт,	Гаалийн хяналт, шалгалтын үйл ажиллагааг эрчимжүүлж, гаалийн	Улс, орон нутгийн төсөвт орох татварын орлогын	хувь	2022	Татварын ерөнхий газар	11.1%	Өгсөх

	орлого бүрдүүлэлт	бүрдүүлэлтэд зарцуулах хугацааг бууруулна.	төлөвлөгөөний биелэлт								
			Эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналт, шалгалтын үйл ажиллагааны хэрэгжилт	хувь	2022	Татварын ерөнхий газар	11.1%	Өгсөх			
			Гаалийн бүрдүүлэлтэд зарцуулах хугацааны бууралт	хувь	2022	Татварын ерөнхий газар	11.1%	Өгсөх			
		Татвар хураалтыг сайжруулж, татварын өрийг бууруулна.			Өмнөх онуудын тайлангаар ногдуулсан татварын өр барагдуулалт	хувь	2022	Татварын ерөнхий газар	11.1%	Өгсөх	
					Өмнөх онуудын хяналт шалгалтаар ногдуулсан өр барагдуулалт	хувь	2022	Татварын ерөнхий газар	11.1%	Өгсөх	
					Тайлант хугацааны татварын тайлангийн ногдол өр барагдуулалт	хувь	2022	Татварын ерөнхий газар	11.1%	Өгсөх	
					Татварын цахим тайлан тушаалт	хувь	2022	Татварын ерөнхий газар	11.1%	Өгсөх	
					"Х" тайлан тушаалтын бууралт	хувь	2022	Татварын ерөнхий газар	11.1%	Өгсөх	
					Хууль тогтоомжийн хуулийн хэрэгжилтийг хангана	Үйл ажиллагааны хэрэгжилт	хувь	2022	Холбогдох албан ёсны тайлан мэдээ	11.2%	Өгсөх
					Хууль тогтоомжийн хуулийн хэрэгжилтийг хангана	Үйл ажиллагааны хэрэгжилт	хувь	2022	Холбогдох албан ёсны тайлан мэдээ	11.2%	Өгсөх
70207	Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр	Төсөл хөтөлбөрийн хэрэгжилт	Хэрэгжилтийн биелэлт	хувь	2023	Сангийн яам	100.0%	Өгсөх			

70301	Гадаад улс орнууд дахь дипломат үйл ажиллагаа	Төсвийн орлогын төлөвлөгөөг батлагдсан хуваарийн дагуу төвлөрүүлнэ.	Төвлөрүүлэх орлогын хэмжээ	тэрбум төгрөг	2022	Гадаад харилцааны яамны тайлан, Гадаад харилцааны яамны вэб хуудас	100.0%	Өгсөх
70303	Олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх	ЮНЕСКО-д биет болон биет бус өвийг бүртгүүлнэ.	ЮНЕСКО-д бүртгүүлэх биет болон биет бус өв	тоо	2022	Гадаад харилцааны яамны тайлан, Гадаад харилцааны яамны вэб хуудас	100.0%	Өгсөх
70304	Гадаад улс оронд байгаа монгол иргэдэд туслах	Гадаад улсад байгаа Монгол Улсын иргэдийн гаргасан хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэнэ.	Гадаад улсад байгаа Монгол Улсын иргэдийн гаргасан хүсэлтийн шийдвэрлэлт	хувь	2022	Гадаад харилцааны яамны тайлан, Гадаад харилцааны яамны вэб хуудас	100.0%	Өгсөх
70305	Гадаад харилцааны бодлого, удирдлага	Монгол Улсын гадаад бодлогыг хэрэгжүүлэх, гадаад улс төр, худалдаа, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ.	Гадаад харилцааны бодлого, удирдлагын чиглэлээр зохион байгуулах сургалт семинар	тоо	2022	Гадаад харилцааны яамны тайлан, Гадаад харилцааны яамны вэб хуудас	20.0%	Өгсөх
			Засгийн газар хоорондын хэлэлцээр	тоо	2022	Гадаад харилцааны яамны тайлан, Гадаад харилцааны яамны вэб хуудас	20.0%	Өгсөх
			Зөвлөлдөх уулзалт, дугуй ширээний уулзалт	тоо	2022	Гадаад харилцааны яамны тайлан, Гадаад харилцааны яамны вэб хуудас	20.0%	Өгсөх
			Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээг хэвлэн нийтлэх тоо	тоо	2022	Гадаад харилцааны яамны тайлан, Гадаад харилцааны яамны вэб хуудас	20.0%	Өгсөх
		Хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлж, айлчлал, арга хэмжээний давтамжийг нэмэгдүүлнэ.	Зохион байгуулах өндөр, дээд түвшний айлчлалын тоо	тоо	2022	Гадаад харилцааны яамны тайлан, Гадаад харилцааны яамны вэб хуудас	20.0%	Өгсөх
70401		Төрийн албаны шинэтгэлийг бэхжүүлнэ.	Хүний нөөцийн аудит	тоо	2019	Төрийн албаны зөвлөл	10.0%	Өгсөх

Төрийн албаны ерөнхий удирдлага		Албан тушаалын давхардлын бууралт	тоо	2019	Төрийн албаны зөвлөл	10.0%	Буурах
	Төрийн жинхэнэ албанд иргэнийг сонгон шалгаруулах, томилох, албан тушаал дэвшүүлэх үйл ажиллагаанд чадахуйн зарчим болон шатлан дэвшүүлэх тогтолцоог мөрдүүлнэ.	Сул орон тоонд сонгон шалгаруулалт явуулах захиалгын шийдвэрлэлтийн хувь	хувь	2019	Төрийн албаны зөвлөл	10.0%	Өгсөх
	Төрийн жинхэнэ албанд иргэнийг сонгон шалгаруулах, томилох, албан тушаал дэвшүүлэх үйл ажиллагаанд чадахуйн зарчим болон шатлан дэвшүүлэх тогтолцоог мөрдүүлнэ.	Шинээр боловсруулах сорил	хувь	2019	Төрийн албаны зөвлөл	10.0%	Өгсөх
	Төрийн албаны зөвлөлийн "Open-Exam" шалгалтын цахим системийг бусад системүүдтэй холбох, хэвийн ажиллагааг хангахад шаардлагатай нэмэлт хөгжүүлэлтийг хийнэ.	Цахим системийн нэмэлт хөгжүүлэлтийн явц	хувь	2019	Төрийн албаны зөвлөл	10.0%	Өгсөх
	Хүний нөөцийн системийн мэдээллийн удирдлагын нэгдсэн сангийн цахим системийг бүрэн хөгжүүлж, нэвтрүүлсэн байна.	Системийн модуль хөгжүүлэлт, нэвтрүүлэлт	хувь	2022	Төрийн албаны зөвлөл	10.0%	Өгсөх
	Төрийн албан хаагчийн гүйцэтгэл, үр дүн, төрийн байгууллагын бүтээмжийг нэмэгдүүлнэ.	Арга зүйн сургалт	тоо	2021	Төрийн албаны зөвлөл	10.0%	Өгсөх
	Төрд учруулсан хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж, улсын төсөвт төвлөрүүлсэн байна.	Төрд учруулсан хохирлын нөхөн төлбөрийн улсын төсөвт төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ	сая төгрөг	2023	Төрийн албаны зөвлөл	10.0%	Өгсөх

